МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт
манлайлна

2021 ENTREPRENEUR
САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭНТРЕПРЕНЁР

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ



INTERNATIONAL FEDERATION
OF ASIAN AND WESTERN PACIFIC
CONTRACTORS' ASSOCIATIONS

INTERNATIONAL FEDERATION
OF CONSULTING ENGINEERS

МБҮА

+976-7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn

Монголын Барилгын
Үндэсний Ассоциаци

РЕДАКЦИ

ХЯНАН ТОХИОСОН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ЭНХБААТАР

НЭГТЭЛ РЕДАКТОР:
Б.ТӨВШИНБОЛОР

ОРОЛЦСОН:
АЖЛЫН АЛБА

АГУУЛГА

НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО:

УДИРДЛАГЫН МАНЛЛАЙЛЫГ ХАНГАЖ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

САЛБАРЫН БОДЛОГО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

ГИШҮҮНЧЛЭЛ, МРКЕТИНГ, СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна



+ 976 7011 1515 www.mnca.mn

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

21 АЙМАГТ АССОЦИАЦИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ байгуулж эхэллээ

АССОЦИАЦИ НЬ САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДТЭЙ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАНА.

- Сургалт, зөвлөгөөн
- Туршлага солилцоо
- Төслүүд, хөрөнгө оруулалт
- Шударга өрсөлдөөн, стандартын хяналт

7011 1515 info@mnca.mn

www.mnca.mn



БАЯН-ӨЛГИЙ **ХОВД** **ДАРХАН-УУЛ**

Аймгуудад САЛБАР ЗӨВЛӨЛ-ийг байгуулаад байна.

МБҮА SINCE 2009 МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ

2026 Зохион байгуулагдах томоохон арга хэмжээнүүд

Зөв зүгт Манлайлна

Арга хэмжээний нэр	Огноо	Зорилго
“Construction market-2026”	2026.04-р сар	МУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, барилга бүтээн байгуулалтын салбарт хэрхэн нөлөөлөх, барилгын зах зээлийн нөхцөл байдал, санхүүжилт хөрөнгө оруулалт, судалгаа зэрэг нэгдсэн мэдээ, мэдээллийг хүргэх.
“Барилгын салбарын Удирдах ажилтнуудад зориулсан ХАБЭА сургалт” *(Төв, Хангайн болон Зүүн бүсийн аймгуудад)*	2026.03-11 саруудад	ХАБЭА-н хууль тогтоомж, эрсдэлийн удирдлага болон байгууллагын ХАБЭА -н зохион байгуулалтын мэдлэг, чадвар олгохоос гадна барилгын үйл ажиллагаа тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах заавар зөвлөгөөг хүргэх.
“Барилгачдаараа Бахархья-2026”	2026.01-12-р саруудад	Барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан байгууллагын болон Гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах компанит ажил.
“Барилгын салбарын ажиллах хүчний асуудал гарц, шийдэл”	2026.05-р сар	Барилга, дэд бүтцийн салбарын ААНБ-уудын ажил олгогчдод нэн шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээ, мэргэжлийн ур чадварын түвшин, хөдөлмөрийн нөхцөл, болон дотоодод дутагдаж буй хүний нөөцийг гадаадаас оруулж ирэх боломжийг бий болгох
Барилгын үйл ажиллаагаааны тусгай зөвшөөрлийн өөрчлөлт-шинэлэлт- үр дүн *Хэлэлцүүлэг, Нээлттэй өдөрлөг*	2026.11-р сар	• Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар олон талын саналыг сонсож, хэлэлцэж, шийдвэр, гаргалгаа, санал хүсэлтийг авах • Салбарт үзүүлэх Ассоциацийн байр суурийг илэрхийлэх, нөлөөлөх.
“Барилгачдын нэгдсэн чуулган-2026”	2026.12-р сар	Барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, нэр хүндийг өсгөх
“Construction Award-2026”	2026.12-р сар	Барилгын салбарын шилдэг ААНБ-уудыг шалгаруулах, тэдгээрийг алдаршуулах
Хэвлэмэл товхимолын нэр		
“МУ-ын барилгын салбар - 100” тоон эмхэтгэл	2026.04-р сар	
“Өнөөдрийг бүтээсэн 100 жил” алдаршуулах товхимол	2026.09-р сар	Салбарт үзүүлэх Ассоциацийн байр суурийг илэрхийлэх, нөлөөлөх. Гишүүдийг сэтгэл ханамжийш дээшлүүлэх.

Арга хэмжээ, товхимлыг ивээн тэтгэн, хамтран ажилласнаар:

- **2026 онд Ассоциацаас зохион байгуулагдаж буй арга хэмжээ бүрт ЛОГО-г байршуулах** / баннер, постер, станд, видео шторк, байгууллагын албан ёсны сошиал холбоосыг сошиал хуудсанд байршуулах гэх мэт/
- **Арга хэмжээнд үйл ажиллагаагааг сурталчлах, танилцуулах**
- **Эмхтгэл, товхимолд өнгөт сурталчилгааг байршуулна.**
- **Бусад**

2026 САЛБАРЫН БОДЛОГО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР




УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ

"ЧИНГИС ХААН" ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ӨРГӨТГӨЛД МОНГОЛЫН БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ НАРЫГ ОРОЛЦУУЛАХ ДЭМЖЛЭГ ХҮСЛЭЭ

Монгол Улсын Засгийн газраас Япон Улсын Засгийн газартай “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын өргөтгөлийн төслийн зээлийн хэлэлцээрийг эхлүүлэхээр ажиллаж буйтай холбогдуулан барилгын салбарын аж ахуйн нэгжүүдийн эрх ашиг, үндэсний эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах үүднээс уг төсөлд салбарын бүтээн байгуулагч нарыг оролцуулах дэмжлэг хүсэхээр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, УЗ-ийн гишүүн Монкон групп ХХК-ийн захирал Ч.Дарханбаатар, Гүйцэтгэх захирал М.Энхбаатар болон МБНХ-ны тэргүүн Ч.Наранбаатар, Материал импекс ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Зориг нар нь Сангийн яам, Зам тээврийн яам, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын төлөөлөгчидтэй 2026.06.23-ны өдөр уулзаж санал солилцлоо.

МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан:

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын гишүүн байгууллагууд нь Монгол Улсын бүтээн байгуулалтын 60 орчим хувийг гүйцэтгэдэг үндэсний компаниудын нэгдэл төдийгүй төрийн чиг үүрэг болох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг 8 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Мөн Монголын барилгын компаниуд сүүлийн 30 жилийн хугацаанд дотоодын хөрөнгө оруулалтаар томоохон барилга, дэд бүтцийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн бөгөөд Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын өргөтгөлийн төслийг гүйцэтгэх техник, технологи, хүний



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ
МН Тауэр, 8 дугаар давхар, 805, 806, 811 тоот
Самбуугийн гудамж 24, 5 дугаар хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар, 15141
Утас: (976) 7011 1515
Цахим шуудан: info@mnca.mn
Цахим хуудас: www.mnca.mn

2026.03.02 № 26/76
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Хүсэлт тавих тухай

Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын мэндийг ергөн дэвшүүлж, Таны амар амгаланг айлтган мэндчилье.

Монгол Улсын Засгийн газраас Япон Улсын Засгийн газартай Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын өргөтгөлийн төслийн зээлийн хэлэлцээрийг эхлүүлэхээр ажиллаж буйтай холбогдуулан барилгын салбарын аж ахуйн нэгжүүдийн эрх ашиг, үндэсний эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах үүднээс дараах хүсэлтийг хүргүүлж байна.

Барилгын салбар нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, дэд бүтцийн хөгжил, ажлын байрны тогтвортой байдалд стратегийн ач холбогдол бүхий, ажиллах хүчний шингээлт өндертэй салбар юм. 2020–2024 оны хугацаанд дотоодын барилгын байгууллагууд 31.6 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсний 95.3 хувийг хувийн хэвшлийн үндэсний компаниуд хэрэгжүүлсэн нь салбарын бодит чадавхыг илэрхийлж байна.

Гэвч гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй томоохон төсөл, хөтөлбөрүүдэд дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоо ерөнхий гүйцэтгэгчийн түвшинд хангагдахгүй, туслан гүйцэтгэгч, зарим тохиолдолд туслангийн туслан гүйцэтгэгчийн түвшинд хязгаарлагдаж, нийт төслийн үнийн дүнгийн 20–30 хувиас хэтрэхгүй байгаа салбарын зүгээс анхааралтай ажиглаж байна.

Тухайлбал, Солонго 1, 2 хороолол, Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв зэрэг төслүүдэд гадаадын аж ахуйн нэгжүүд ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан бөгөөд

000146

нөөц, төслийн удирдлагын бүрэн чадавхтай болсныг онцоллоо.

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн хувьд зээл олгогч улсын аж ахуйн нэгжийг ерөнхий гүйцэтгэгчээр сонгон шалгаруулах нөхцөл хэлэлцээрт тусгагддаг практик байдаг нь ойлгомжтой. Гэвч уг ерөнхий гүйцэтгэгч нь Монгол Улсын аж ахуйн нэгжүүдтэй шууд хамтран ажиллах, дотоодын компаниудын оролцоог тодорхой хувь, багц, чиглэлээр баталгаажуулах зохицуулалтыг зээлийн хэлэлцээр болон төслийн хэрэгжилтийн баримт бичигт тусган өгөх шаардлагатай гэж үзэж байна.

Мөн зарим төслүүдэд ерөнхий гүйцэтгэгч нь гуравдагч улсын аж ахуйн нэгжүүдийг туслан гүйцэтгэгчээр оролцуулж буй нь Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн эрх ашиг, эдийн засгийн өгөөжийг бууруулах эрсдэл дагуулж байна. Одоогоос 10 орчим жилийн өмнө Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын анхны барилгын төсөл хэрэгжих үед Монголын 70 гаруй аж ахуйн нэгжүүд шууд бус, олон шат дамжсан хэлбэрээр оролцож, төслийн гол

гүйцэтгэлийг хийсэн хэдий ч нийт үр өгөөжөөс хязгаарлагдмал хувь хүртсэн туршлага бий. Энэхүү жишгийг давтахгүй байхыг онцгойлон уламжиллаа.

Уулзалтын үеэр тус “Ажлын хэсэг”-ийн гишүүд болох Япон Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага "ЖАЙКА"-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Миаги Кэнсүкэ, Эрчим хүч байгаль орчин зам тээвэр хот байгуулалтын хариуцсан суурин төлөөлөгч Шида Косуке, Зүүн ба Төв ази хариуцсан дарга Мураками Сатоши болон СЯны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Цэнгүүнжав нарын зүгээс Япон Монголын хөрөнгө оруулагч, ижил төстэй компаниудыг холбох, хамтран ажиллах уулзалтуудыг зохион байгуулахаас гадна дотоодын аж ахуйн нэгжүүдийн саналыг тусгах, харилцан ойлголцох, дараагийн хэлэлцээрийн түвшинд саналуудаа нэгтгэхээр ойлголцолд хүрлээ.





МБҮА ТББ СТРАТЕГИЙН ТОМООХОН ТӨСЛҮҮДЭД ҮНДЭСНИЙ АЖ АХУЙ НЭГЖҮҮДИЙН ОРОЛЦООГ БОДЛОГЫН ТҮВШИНД ДЭМЖИХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЛЭЭ



Барилгын салбар нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, дэд бүтцийн хөгжил, ажлын байрны тогтвортой байдалд стратегийн ач холбогдолтой, ажиллах хүчний шингээлт өндөртэй салбарын нэг билээ.

2020–2024 оны хугацаанд дотоодын барилгын байгууллагууд нийт 31.6 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд үүний 95.3 хувийг хувийн хэвшлийн үндэсний компаниуд хэрэгжүүлсэн нь Монголын барилгын салбарын бодит чадавх, туршлагыг харуулж байна.

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын төслийн эхний шатны одоогоос 10 гаруй жилийн өмнө хэрэгжүүлсэн барилга бүтээн байгуулалтын ажилд Монголын 70 гаруй аж ахуйн нэгжүүд шууд бус болон олон



шат дамжсан хэлбэрээр оролцож, төслийн тодорхой гүйцэтгэлүүдийг хэрэгжүүлсэн хэдий ч нийт эдийн засгийн үр өгөөжөөс хязгаарлагдмал хэмжээнд хүртсэн туршлага бий.

Иймд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-аас Монгол Улсын Ерөнхий сайдад стратегийн томоохон төслүүдийн хүрээнд үндэсний аж ахуйн нэгжүүдийн оролцоог бодлогын түвшинд дэмжих чиглэлээр дараах саналуудыг хүргүүллээ.



Үүнд:

- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих стратегийн төслүүдийн зээлийн болон хамтын ажиллагааны хэлэлцээрт Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн оролцоог тодорхой хувь, багц, чиглэлээр тусгах;
- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих стратегийн төслүүдийн зээлийн болон хамтын ажиллагааны хэлэлцээрийг боловсруулах шатанд үндэсний хувийн хэвшлийн санал, бодит чадавхыг тусгах чиглэлээр салбарын мэргэжлийн холбоодтой тогтмол хамтран ажиллах механизмыг бүрдүүлэх;
- Ерөнхий гүйцэтгэгч компаниуд Монголын аж ахуйн нэгжүүдтэй шууд хамтран ажиллах, түншлэх зохицуулалтыг хэлэлцээрийн түвшинд тусгах;
- Тендерийн шалгуур үзүүлэлтийг үндэсний компаниудын бодит чадавх, туршлагад нийцүүлэн боловсруулах, мэргэжлийн холбоодын санал, дүгнэлтийг тусгах механизмыг бүрдүүлэх;
- Үндэсний аж ахуйн нэгжүүдийг консорциум хэлбэрээр нэгдэн оролцох боломжийг бодлогоор дэмжих;
- Стратегийн төслүүдийн хүрээнд технологи дамжуулах, инженер техникийн чадавх бэхжүүлэх, үндэсний компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх тогтолцоог үе шаттай бүрдүүлэх.
- МБҮА ТББ нь стратегийн төслүүдийн хэрэгжилтэд олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжихийн зэрэгцээ үндэсний аж ахуйн нэгжүүдийн бодит оролцоо, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын чухал хэсэг гэж үзэж байна.

ГАЗРЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛААГҮЙ ТОХИОЛДОЛД ГЭРЧИЛГЭЭГ ЦУЦЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ

Н.Баярсайхан: Газрыг зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдолд гэрчилгээг цуцлах эрх зүйн зохицуулалт байдаг ч хэрэгжилт нь сул байна. Үүний улмаас “газар” хэмээх баялаг хөгжүүлэлт хүлээсэн актив болж, эрэлт нийлүүлэлтийн хэлхээг хязгаарлаж байна.



Дэлгэрэнгүй: https://www.mongolianeconomy.mn/article/25566

УИХ-ЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД Э.БАТ-АМГАЛАН БОЛОН ХОЛБОГДОХ

УДИРДЛАГУУД МБҮА ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАЖ, ЦААШДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР САНАЛ СОЛИЛЦЛОО



(2026.06.04-ны өдөр УИХ-ын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам сайд Э.Бат-Амгалан Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын үйл ажиллагаатай танилцах, цаашдын хамтын ажиллагааны бодлого чиглэлийг тодорхойлох уулзалтыг хийлээ.
Уулзалтаар салбарын тулгамдсан асуудлуудын талаар нэгдсэн ойлголтод хүрч, төр–хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бодит үр дүнд чиглүүлэх, цаашдын хамтын ажиллагааны чиглэл, боломжийг хамтдаа тодорхойлох зорилготой уулзалт боллоо. Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан МБҮА ТББ бол манай салбарын тэргүүлэх мэргэжлийн төрийн бус байгууллага бөгөөд МБҮА ТББ-ын үүсгэн байгуулагчид, гишүүн аж ахуйн нэгжүүд 2000 оноос хойшхи өнөөдрийн Улаанбаатар хотын барилгын хөгжлийг авч явж буйг дурдаад Засгийн газар, яамны зүгээс хийж хэрэгжүүлж буй хууль эрх



зүйн шинэчлэл, цаашид хэрэгжүүлэхээр зорьж буй бодлого үйл ажиллагааны чиглэлээр товч мэдээлэл өгөөд энэхүү эрх зүйн шинэчлэл, бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ салбарын мэргэжлийн байгууллагуудтай тэр дундаа салбарын тэргүүлэх мэргэжлийн холбоо Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ хамтран ажиллана гэдгээ илэрхийллээ. Мөн МБҮА ТББ-ын төлөөллийг Сайдын зөвлөл, Норм нормативын сангийн удирдах зөвлөл, Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах, салбарын норм норматив, стандарт дүрмийг шинэчлэх, ногоон технологи, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, барилгын чанар аюулгүй байдлыг сайжруулах, барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл, техникийн нөхцөл олголтыг бүрэн цахимжуулах зэрэг асуудлаар өөрсдийн санал, шийдлээ танилцуулж, энэхүү асуудлуудыг шийдвэрлэхэд ХББОСЯ-тай хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ.

МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР: ТАНХИМ ДАНГААРАА “САНАЛ ӨГДӨГ БАЙГУУЛЛАГА” БАЙХААС ИЛҮҮ, САЛБАРУУДЫН НЭГДСЭН ДУУ ХООЛОЙГ ИНСТИТУЦЧИЛСЭН БАЙДЛААР НЭГТГЭДЭГ ПЛАТФОРМ БОЛОХ ЁСТОЙ

МБҮА ТББ нь МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд 2026.02.27-ны өдөр танхим Удирдах зөвлөлийн ээлжит хурлаа хийлээ. Хурлаар 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн танилцуулга, Хяналтын зөвлөлийн танилцуулгыг хийж улмаар 2026 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлээ танилцуулж энэ оныг "Бодлогын өмгөөллийн жил" болгон зарлахаар тогтлоо. МОҮҮАрбитрт хэрэг хянан шийдвэрлэсэн арбиртч, нарийн бичгийн дарга, илтгэгч нарт мөнгөн урамшуулал олгох журмын шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, Арбитрын үндсэн зардал болон нэмэлт зардлын хэмжээ тооцох журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг танилцуулан батлууллаа. Мөн Монголын олон улсын Арбитрын Арбитрчдын нэрсийн шинэчилсэн жагсаалтыг танилцууллаа.

Уг хуралд танхимын Удирдах зөвлөлийн гишүүн, МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь:



...“Бизнесийн орчны өмгөөллийн жил” гэж зарлаж байгаа энэ үед нэг чухал байж болох нэг асуудлыг онцолж хэлмээр байна. Өнөөдөр мэргэжлийн холбоод салбар салбараараа төртэй харилцаж байна. Гэвч зөвшөөрлийн шат дамжлага, барилга эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, зохицуулалтын давхцал зэрэг салбарын хөгжилд чөдөр тушаа болдог олон олон асуудлыг дангаар нь шийдүүлэхэд хүч хүрэхгүй байна. Эдгээр нь нэг салбарын биш — нийт бизнесийн орчны системийн асуудал болсон.

Тиймээс танхим мэргэжлийн холбоодын нэгдсэн дуу хоолойг институцчилсэн байдлаар нэгтгэдэг бодит механизм бий болгох шаардлагатай гэж үзэж байна. Танхим дангаараа “санал өгдөг байгууллага” байхаас илүү, салбаруудын нэгдсэн дуу хоолойг институцчилсэн байдлаар нэгтгэдэг платформ болох ёстой. Тиймээс 2026 оны төлөвлөгөөнд Танхим–мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааны тогтолцоог тодорхой тусгаж, нэгдсэн байр суурьтайгаар төртэй харилцах механизмыг бий болгоё. Учир нь бодлогын түвшинд нөлөөлөх хүч ганц нэгээрээ биш — нэгдэж байж бий зохион байгуулалтын хувьд дүрмийн болоод журмын зөрчилтэй болсон, бүх гишүүдийн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулья гэдэгт талууд нэгдсэн байр суурьтай болсон талаарх мэдээллийг хүргэлээ. болдог. Хэрэв Танхим энэ үүргийг авахгүй бол хэн ч авахгүй гэдэг саналаа илэрхийллээ.

МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ЗӨВШИЛЦӨХ АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТИЙГ ТАНИЛЦУУЛЖ ХОЛБОГДОХ ШИЙДВЭРҮҮДИЙГ ГАРГАЛАА

2026.03.17-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар “2025 оны Бүх гишүүдийн VI чуулгантай холбоотой гишүүдийн гомдлын дагуу нягтлан шалгах Ажлын хэсгийн ахлагч Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр үүссэн нөхцөл байдлын талаар шалгалтын дүнг танилцуулсан бөгөөд тус дүгнэлтийн дагуу бүх гишүүдийн VI чуулган дүрмийн болон журмын ноцтой зөрчилтэй болсон болохыг тогтоож, улмаар Бүх гишүүдийн чуулганы үед гарсан дүрэм, журмын зөрчлийг шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээний талаар зөвшилцөх Ажлын хэсгийг (Н.Баярсайхан, Д.Энхтөр Б.Хүрэлхүү, Б.Баасансүрэн, Р.Даваасүрэн, Г.Эрдэнэчимэг нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй) байгуулснаар уг хурлыг 2026.03.27-ны өдрийг хүртэл завсарлуулсан билээ.

Уг хурлыг товлосон хугацаа буюу 2026.03.27-ны өдөр Жигүүр гранд групп ХХК-ийн байранд 15:00 цагаас биет 17, цахим 14 нийт 31 гишүүний ирцтэйгээр хурлыг Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр удирдан зохион байгуулж зөвшилцөх Ажлын хэсэг хоёр удаа хуралдаж Бүх гишүүдийн VI чуулган нь

Харин Дэд ерөнхийлөгч Б.Хүрэлхүү зөвшилцлийн үр дүнг Удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулж тус Ажлын хэсгийн хуралдаанаас:

- Бүх гишүүдийн VI чуулган нь дүрмийн болон журмын ноцтой зөрчилтэй болсон





учир гаргасан алдааг засах Ажлын хэсэг байгуулах

- Дахин маргаан гаргахгүйн талд аль аль талаасаа хуулийн зөвлөхүүд ажиллуулахЧуулганы хурлын даргаар МБҮА ТББ-ын үүсгэн байгуулагчдын нэгээр тавих
- Арбитр, болон Фидик нь МБҮА ТББ-ын нэр дээр байж, ашиг орлого нь 100% байгуулагдаа орох ёстой гэсэн асуудлаар нэг ойлголттой болж дараагийн шатанд хүрч ажиллах болсныг мэдэгдлээ.


Байгууллагадаа үүсээд буй асуудлыг шийдвэрлэхийн төлөө байгууллагынхаа үнэт зүйл, зарчмыг баримтлан зөвшилцөн ажилласан Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр, Б.Хүрэлхүү, Удирдах зөвлөлийн гишүүн Б.Баасансүрэн, Г.Эрдэнэчимэг нартаа нийт гишүүд талархал илэрхийлж баяр хүргэлээ.

Ийнхүү 2026 оны анхдугаар удирдах зөвлөлийн хурлаар бид бүхэн хамтдаа зөвшилцөх, ойлголцож, үүсээд байсан асуудлаа шийдвэрлэж чадлаа.

Мөн МБҮА ТББ-ын Ажлын албаны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийг батлан, гүйцэтгэх захирлын үүргийг хавсран гүйцэтгэж байсан М.Энхбаатарыг Гүйцэтгэх захирлаар жинхлэн томиллоо. Үүний зэрэгцээ Фидикийн сургалт, орчуулгын үйл ажиллагаа, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зэрэг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад шаардлагатай чухал тогтоол шийдвэрүүдийг гаргалаа.

Ийнхүү ээлжит Удирдах зөвлөлийн хуралдаа цаг зав, сэтгэл оюунаа зориулан ирж МБҮА ТББ-ынхаа бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах үндсэн үүргээ биелүүлсэн та бүхэндээ баярлалаа. Мөн хурлыг зохион байгуулахад заал танхимаар тусалсан Жигүүр гранд групп ХХК-ийн ТУЗ-ын дарга, МБҮА ТББ-ын үүсгэн байгуулагч, Хүндэт ерөнхийлөгч Д.Баттөр болон Ерөнхий захирал Б.Халиунаа нартаа талархал илэрхийлье.

БИД ЗӨВ ЗҮГТ МАНЛАЙЛНА



МБҮА

МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ЗӨВШИЛЦӨХ АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТИЙГ ТАНИЛЦУУЛЖ ХОЛБОГДОХ ШИЙДВЭРҮҮДИЙГ ГАРГАЛАА

2026.03.17-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар **"2025 оны Бүх гишүүдийн VI чуулгантай холбоотой гишүүдийн гомдлын дагуу** нягтлан шалгах Ажлын хэсгийн ахлагч Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр үүссэн нөхцөл байдлын талаар шалгалтын дүнг танилцуулсан бөгөөд тус дүгнэлтийн дагуу бүх гишүүдийн **VI чуулган дүрмийн болон журмын ноцтой зөрчилтэй** болсон болохыг тогтоож, улмаар Бүх гишүүдийн чуулганы үед гарсан дүрэм, журмын зөрчлийг шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээний талаар зөвшилцөх Ажлын хэсгийг (Н.Баярсайхан, Д.Энхтөр Б.Хүрэлхүү, Б.Баасансүрэн, Р.Даваасүрэн, Г.Эрдэнэчимэг нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй) байгуулснаар уг хурлыг 2026.03.27-ны өдрийг хүртэл завсарлуулсан билээ.

Уг хурлыг товлосон хугацаа буюу 2026.03.27-ны өдөр Жигүүр гранд групп ХХК-ийн байранд 15:00 цагаас биет 17, цахим 14 нийт 31 гишүүний ирцтэйгээр хурлыг Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр удирдан зохион байгуулж зөвшилцөх Ажлын хэсэг хоёр удаа хуралдаж Бүх гишүүдийн VI чуулган нь зохион байгуулалтын хувьд дүрмийн болоод журмын зөрчилтэй болсон, бүх гишүүдийн эзэлжит бус чуулганыг зарлан хуралдуулья гэдэгт талууд нэгдсэн байр суурьтай болсон талаарх мэдээллийг хүргэлээ.

Харин Дэд ерөнхийлөгч Б.Хүрэлхүү **зөвшилцлийн үр дүнг Удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулж тус Ажлын хэсгийн хуралдаанаас:**

- Бүх гишүүдийн VI чуулган нь дүрмийн болон журмын ноцтой зөрчилтэй болсон учир гаргасан алдаат засах Ажлын хэсэг байгуулах
- Дахин маргаан гаргахгүйн талд аль аль талаасаа хуулийн зөвлөхүүд ажиллуулах
- Чуулганы хурлын даргаар МБҮА ТББ-ын үүсгэн байгуулагчдын нэгээр тавих
- Арбитр, болон Фидик нь МБҮА ТББ-ын нэр дээр байж, ашиг орлого нь 100% байгуулагдаа орох ёстой гэсэн асуудлаар нэг ойлголттой болж дараагийн шатанд хүрч ажиллах болсныг мэдэгдлээ.

Байгууллагадаа үүсээд буй асуудлыг шийдвэрлэхийн төлөө байгууллагынхаа үнэт зүйл, зарчмыг баримтлан зөвшилцөн ажилласан Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр, Б.Хүрэлхүү, Удирдах зөвлөлийн гишүүн Б.Баасансүрэн, Г.Эрдэнэчимэг нартаа нийт гишүүд талархал илэрхийлж баяр хүргэлээ.

Ийнхүү 2026 оны анхдугаар удирдах зөвлөлийн хурлаар бид бүхэн хамтдаа зөвшилцөх, ойлголцож, үүсээд байсан асуудлаа шийдвэрлэж чадлаа.

Мөн МБҮА ТББ-ын Ажлын албаны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийг батлан, гүйцэтгэх захирлын үүргийг хавсран гүйцэтгэж байсан М.Энхбаатарыг Гүйцэтгэх захирлаар жинхлэн томиллоо. Үүний зэрэгцээ Фидикийн сургалт, орчуулгын үйл ажиллагаа, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зэрэг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад шаардлагатай чухал тогтоол шийдвэрүүдийг гаргалаа.

Ийнхүү ээлжит Удирдах зөвлөлийн хуралдаа цаг зав, сэтгэл оюунаа зориулан ирж МБҮА ТББ-ынхаа бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах үндсэн үүргээ биелүүлсэн та бүхэндээ баярлалаа. Мөн хурлыг зохион байгуулахад заал танхимаар тусалсан Жигүүр гранд групп ХХК-ийн ТУЗ-ын дарга, МБҮА ТББ-ын үүсгэн байгуулагч, Хүндэт ерөнхийлөгч Д.Баттөр болон Ерөнхий захирал Б.Халиунаа нартаа талархал илэрхийлье.

Бид Зөв зүгт манлайлна





МБҮА ТББ-ЫН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ Л.АРИУНБОЛД БНУУ-ЫН ӨРГӨМЖИТ КОНСУЛААР ТОМИЛОГДЛОО

БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКСТАН УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН ЯАМ НООТ БИЧИГ

Ноён Лхагважавын Ариунболд нь Монгол Улс дахь Бүгд Найрамдах Узбекстан Улсын Өргөмжит консулаар томилогдсон болно.

Улаанбаатар хотод байрлах Бүгд Найрамдах Узбекстан Улсын Өргөмжит консулын газрын консулын тойрог нь Монгол Улсын бүх аймгийг хамарна. Иймд Бүгд Найрамдах Узбекстан Улсын Гадаад хэргийн яам нь Монгол Улсын Засгийн газраас ноён Лхагважавын Ариунболдыг энэхүү албан тушаалд нь хүлээн зөвшөөрч, түүнд консулын үүргээ хэрэгжүүлэх боломжийг олгон, таатай хандаж, шаардлагатай бүх талын дэмжлэг үзүүлж, түүний албан тушаалын эрх зүйн байдалд нийцүүлэн эдлэх эрх ямба, дархан эрх, хөнгөлөлтийг олгохыг хүсэж байна.

Бүгд Найрамдах Узбекстан Улсын Гадаад хэргийн сайд

Бахтиёр Саидов (гарын үсэг)

Ташкент хот

2026 оны 6 дугаар сарын 17

Дугаар: 08-24/14289

BUILD MONGOLIA 2026 ҮЗЭСГЭЛЭНД САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭГЧИД ОРОЛЦОЖ БАЙНА

Барилга, эрчим хүч, дэд бүтцийн салбарын компаниуд, үйлдвэрлэгчид, мэргэжилтнүүд нэг дор цуглаж, сүүлийн үеийн техник, технологи, шийдлүүдээ танилцуулдаг BUILD MONGOLIA 2026 үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээ 2026.04.09-ны өдөр болж Нийслэлийн Орон Сууцны Корпорацийн Гүйцэтгэх захирал М.Говьсайхан, МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Сэргээгдэх Эрчим Хүч Үйлдвэрлэгчдийн Холбооны Ерөнхийлөгч Ж.Осгонбаатар нар нар үг хэлж нээлээ.

Уг арга хэмжээний нээлтэд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь

Өнөөдрийн барилгын салбар бол зөвхөн бетон, төмөр биш. Энэ бол технологи, стандарт, системийн нийлбэр болж байна. Ирээдүйд энэ салбарт амжилттай байхыг хурд тодорхойлохгүй. Харин ухаалаг шийдэл, чанар, стандарт тодорхойлно.

Нөгөө талаас, Монголын барилгын стандартыг олон улсын түвшинд хүргэхэд салбарын компаниудын оролцоо, хамтын ажиллагаа нэн чухал.



СТАНДАРТ ГЭДЭГ БОЛ зөвхөн төрөөс тавьдаг шаардлага биш. Энэ бол салбар өөрөө хамтдаа тогтоож, хамтдаа мөрдөж, хамтдаа хамгаалдаг үнэт зүйл юм.

Энэ чиглэлд МБҮА нь салбарын оролцогчдыг нэгтгэсэн, нээлттэй, хамтын ажиллагаанд суурилсан платформ байж, чиглүүлэгч үүрэг гүйцэтгэх боломжтой гэж бид үзэж байна. Энэ үүргээ зохих ёсоор биелүүлсээр ч ирлээ.

Иймд та бүхнийг энэ үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хамтран ажиллахыг уриалж байна.

Бид нэг чухал зүйлийг ойлгох ёстой. Бид барилга барьж байгаа биш, МОНГОЛЫН ИРЭЭДҮЙН ОРЧНЫГ БҮТЭЭЖ БАЙНА.

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Улсын Их Хурлын дарга Н.Учрал нь Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2025.12.17-ны өдөр өргөн барьсан бөгөөд зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, зах зээлд нэвтрэхэд аж ахуйн нэгжүүдэд тулгардаг саад хоригийг багасгах, хуульд нийцээгүй захиргааны хэм хэмжээний акт, журмаар холбогдох харилцааг зохицуулж, зөвшөөрөл олголтыг хүндрүүлж байгааг арилгах, цахим болгож, зөвшөөрөл авах нөхцөлийг шуурхай, хүндрэл чирэгдэлгүй болгохоор төсөл холбогдох зохицуулалтыг тусгасан байна.

Тус хуулийн үзэл баримтлалын талаар МБҮА ТББ-ын гишүүн байгууллагууд болох барилгын компанийнхан цувралаар байр сууриа илэрхийлж байна.

МБҮА ТББ-ын Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар: ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ 1-3 ХОНОГТ БАГТААН ОЛГОДОГ БОЛГОСОН



МБҮА ТББ нь 2018 оноос барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг салбарын Түншлэгч /7/ төрийн бус байгууллагатай хамтран давхар хяналтын дор хэрэгжүүлж байгаа нь салбартаа төдийгүй бусад салбарт төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны САЙН ЖИШИГ болж байгаа билээ.

Тухайлбал Дэлхийн банк Монгол Улсын БҮАТЗ олгох үйл ажиллагааг төрийн бус байгууллагад шилжүүлснээр БИЗНЕСИЙН ОРЧИН сайжирч “DOING BUSINESS” индексийн үзүүлэлтээр дэлхийн 190 орноос 29-р байранд ЭРЭМБЭЛЭГДСЭН-ийг олон нийтэд зарлаж байсан билээ.

Бид БҮАТЗ олгох үйл ажиллагааг 2019 онд хагас цахимжуулсан бол 2021 оноос бүрэн цахимжуулж төрийн үйлчилгээний ХУР, ДАН, И-МОНГОЛ системүүдтэй холбож, барилгын салбарын нэгдсэн мэдээллийн санг бий болгон холбосон. Энэ систем нь хүний оролцоогүй, ил тод, нээлттэй, түргэн шуурхай үйлчилгээтэй, аливаа дундын зуучлалгүй, салбарын инженер, техникийн ажилтнуудын статистик тоон үзүүлэлтийг нэгтгэсэн, ХҮНД СУРТАЛ, АВЛИГААС АНГИЖРУУЛСАН СИСТЕМИЙГ Монгол Улсад нэвтрүүлснээрээ онцлог, давуу талтай болсон юм.

Гэсэн ч барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлт гаргах, хянах, шийдвэрлэх үйл ажиллагаа нь цаасан материал бүрдүүлэлт ихтэй, ирүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах, тодруулах, лавлагаа авах гэх мэт хүний оролцоо ихтэй, цаг хугацаа шаардсан үйл ажиллагаатайгаас гадна мэдээллийн үнэн зөв, баталгаат байдал хангалтгүй, бусад мэдээллийн сангийн цахим системүүдтэй холбогдох боломжгүй байсан зэрэг хүндрэл, дутагдалтай асуудлуудыг цэгцлэх хүрээнд www.license.mn системд буюу E-mongolia-д 2025.09.05-ны өдрөөс шилжүүлснээр тусгай зөвшөөрөл авахад дунджаар 21 хоног зарцуулдаг байсан бол 3 хоногт багтаан тусгай зөвшөөрлийг авах боломжтой болоод байна.


Мөн 2026 оноос Зөвшөөрлөө аваад үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан хяналт тавих ажлыг эрчимжүүлэхээр ажиллахаар болоод байна.

МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч, NCD GROUP ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Хүрэлхүү: ШААРДЛАГАА ХАНГАСАН Л БОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛДАГ БАЙМААР БАЙНА



Бизнес эрхлэгчийн хувьд төрөөс гаргаж байгаа Зөвшөөрөлтэй холбоотой шийдвэрийг алгаа ташаад хүлээж авч байна. Монгол Улс байгаль цаг уурын хувьд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх хугацаа тун бага байдаг бөгөөд олдож байгаа хугацаандаа төрийн элдэв бичиг цаасны ажил гэхээсээ бүтээн байгуулалтын ажилдаа төвлөрөх, цаг заваа зарцуулах шаардлагатай байдаг. Тиймээс бодит амьдрал дээр зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа доголдолгүй тохиолдолд үйл ажиллагааг явцын хяналтаар шууд сунгадаг байх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг цэгцлэх, багасгах, эрх зүйн зохицуулалтыг ойлгомжтой болгох шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл юуг нь зөвшөөрлөөр олгох юм, юуг нь мэдэгдлээр эрхлэх юм гэдэг үйл ажиллагааны жагсаалтыг тодорхой болгож, холбогдох журам, хяналт тавих зохицуулалтыг сайжруулж, зөвшөөрөл, мэдэгдэл хүлээн авах төрийн байгууллагын бүрэн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг маш тодорхой болговол аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа явуулахад амар хялбар болохоор байна.

МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Монкон групп ХХК-ийн Ч.Дарханбаатар: ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ МАНАЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ТҮЛХЭЦ БОЛНО



Манай компани Монгол орныхоо хөгжил, дэвшилд өөрсдийн хувь нэмрийг оруулж гар бие оролцон салбарын хөгжлийг дэлхийн түвшинд хүргэх зорилго тавин үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш багагүй хугацаа өнгөрчээ.

Бид хэрэглэгчид, захиалагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан өнгө үзэмж, чанар технологийн шаардлагад бүрэн нийцсэн дээд зэргийн тав тух сайтай барилгын иж бүрэн ажлыг гүйцэтгэхийг зорьж ажиллахын зэрэгцээ барилга угсралтын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж ажиллахад ихээхэн анхаарал хандуулдаг ба энэ чиглэлээр салбартаа сүүлийн 3 жил тэргүүлэгч болон ажиллаж байна.

Миний болоод манай салбарынхны хувьд УИХ-ын дарга Н.Учралын өргөн бариад байгаа Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг зүй ёсоор талархан хүлээн авч байна. Хуулийн өөрчлөлтөөр Зөвлөх үйлчилгээг энгийн зөвшөөрлийн төрөлд оруулж бүрэн цахимжуулах гэж байгаа нь

зөв зүйтэй бөгөөд энгийн зөвшөөрлийг 5 жилээр, тусгай зөвшөөрлийг 10 жилээр олгохоор заагдсан нь аж ахуйн нэгжүүдэд эерэг, таатай боломжийг олгож байна гэж харж байгаа. Энэ нь бизнес эрхлэгч бидэнд таатай орчин бүрдэж, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгаж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн эдийн засгийг бүрдүүлж, аж ахуй эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах суурь зарчим, зохицуулалтыг бий болгох юм байна гэж ойлгосон.

МБҮА ТББ-ЫН УЗ-ИЙН ГИШҮҮН, БАРМОН ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ш.ҮНЭНБАТ: МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАД ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ



Төрийн үйл ажиллагаанд шинэ менежментийн аргыг нэвтрүүлэх буюу төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, зардлыг багасгах, үйлчилгээ үзүүлэх болон худалдан авах чиг үүргийг салгах, төрийн үйлчилгээг хувийн хэвшлээр гэрээгээр гүйцэтгүүлэх болон хувьчлах хэрэгжүүлснээр үр дүн нь нийгэмд буюу ААНБ-уудад л сайнаар нөлөөлнө. Тухайлбал ТББ-ууд нь иргэний нийгмийн нэг чухал төлөөлөл болж байдаг бөгөөд төртэй түншлэл тогтоох бус харин нийгэмд төрийн үйл ажиллагаанд хяналт тогтоох үүрэгтэйн хувьд тусгай зөвшөөрлийн ард яригддаг хүнд суртал, авлигын асуудал бүрэн арилна гэдэгт итгэлтэй байна.

Сая ч УИХ-ын дарга Н.Учрал зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, зах зээлд нэвтрэхэд аж ахуйн нэгжүүдэд тулгардаг саад хоригийг багасгах хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь цагаа олсон зөв шийдвэр бөгөөд төр юм бүхнийг өөрөө биш Мэргэжлийн холбоодод өгч хяналтаа тавих нь хамгийн зөв шийдвэр гэдгийг манай МБҮА ТББ тодхоноо харуулж байгаа.

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ГАРЦ, ШИЙДЭЛ УУЛЗАЛТЫГ БАРИЛГЫН САЛБАРЫНХТАЙ ХИЙЛЭЭ



Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин ахлан ажиллаж байгаа ба 2026.03.04-ны өдөр УИХ-ын даргын зөвлөх С.Тэнгис тэргүүтэй гишүүд ХБОСЯ-ны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга Д.Батзориг, Хуулийн хэлтсийн дарга Б.Сүхбат, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар, БМҮХ-ны Гүйцэтгэх захирал Г.Цэрмаа нартай барилгын салбарын тусгай зөвшөөрлийн программ хангамж, хууль эрх зүйн өнөөгийн нөхцөл байдлын талаар санал солилцлоо.

МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар нь:

-Тусгай зөвшөөрөл олгоход 14 шат дамжлагаар дамждаг байсныг 7 болгон хөнгөвчилж, зөвшөөрлийг ажлын 1-3 хоногт багтаан олгодог болсон болоод license.mn программ хангамж зөвшөөрөл олголтын явцын талаар мэдээлэл өглөө.

-Мөн Зөвшөөрлийн хуулийн нэмэлт, өөрчлөлт, хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор:

-Тусгай зөвшөөрлийн бүхий л эрх болох инженер техникийн ажилтнуудын шилжилт хөдөлгөөний асуудлыг л нэг байгууллагад өгөх,

-Тусгай зөвшөөрлийг олгоход тэмдэгтийн хураамжийг заалт бүрээр төлж байгаа байдал болон тэмдэгтийн хураамжийг төлөхгүй 3 хонох юм бол хүчингүй болгохоор хуулийн зохицуулалт байгаа нь аж ахуйн нэгжүүдэд хүндрэл үүсгэж байгааг дурдлаа. Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх нь энгийн зөвшөөрлийн төрөлд багтдаг бөгөөд барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авахад шаардаж буй материал нь төр өөрөө хянаж, шалгадаг мөртлөө дахин зөвшөөрөл олголтын байдлаар өгч байгаа нь аж ахуйн нэгжүүдэд хүндрэл үүсгэж байгааг төр өөртөө байгаа мэдээллийг дахин шаарддаг бус цахим байдлаар түргэн шуурхай шийдвэрлэх бүгдийг тус зөвшөөрлийг Мэдэгдэл хэлбэр рүү шилжүүлэх боломжтойг онцлов.

-Мөн барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл гэж мөн эхлүүлэх зөвшөөрөл авахтайгаа дүйцэхүүц хүндрэлтэй зөвшөөрөл байдаг. Төр барилга барих зөвшөөрлөө өгчихсөн тул дахин зөвшөөрөл авдаг бус үүнийг мэдэгдлийн хэлбэрт шилжүүлэх боломжтой байна гэсэн саналуудыг тавьлаа.

-Тавьсан саналыг Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин маш зөв зүйтэй санал байна. Хуулийн нэмэлт өөрчлөлтөнд тусгах чиглэлээр анхааран ажиллах болно. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг барилгын мэргэжлийн төрийн бус байгууллагуудаараа хэрэгжүүлж байгаа нь үлгэр жишээ зөв жишиг бөгөөд зөвшөөрөлтэй холбоотой авлига, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгаж, аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэн ажиллаж САЙН ЖИШИГ болж буйг онцоллоо.

ЗӨВШӨӨРЛИЙГ ОЙЛГОМЖТОЙ, ХҮНДРЭЛГҮЙ ӨГЧ БАЙГАА БОДИТ ЖИШЭЭ НЬ БАРИЛГЫН САЛБАР БАЙГААГ ДУРДЛАА

(эх сурвалж: Ийгл ТВ)



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТАЛААР УИХ-ЫН ГИШҮҮН Г.ЛУВСАНЖАМЦТАЙ МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД САНАЛ СОЛИЛЦЛОО

МБҮА ТББ-ын удирдлагууд болох Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Гүйцэтгэх захирал М.Энхбаатар болон гавъяат барилгачин Шагдаррагчаа нар Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж санал авч буйтай холбогдуулан хуулийн шинэчлэлт, өөрчлөлтийн талаар УИХ-ын гишүүн Г.Лувсанжамцтай санал солилцлоо.



Уулзалтаар Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгад хуулийн зохицуулалт, давхардал, хийдэл, ямар зөрчил байгаа талаар санал солилцсон бөгөөд УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц: Өнгөрсөн 2024-2025 онд салбарынхантай маш олон удаа уулзалтыг зохион байгуулж, саналыг сонсож улмаар хуульд тусган боловсруулаад байгаагаа онцоллоо.

✅Мөн хуулийн төсөл өргөн баригдах гэж байгаа энэ цаг үед мэргэжлийн холбоодууд, салбарынхан тус хуульд дахин саналуудаа нэгтгэх, нэг байр суурьтай байхыг чухалчлаад ойрын үед саналуудаа нэгтгэн албан ёсоор өгөх тал дээр талууд нэг ойлголтод хүрлээ.

ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГЫГ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАД ТАНИЛЦУУЛЛАА

2025 оны байдлаар улсын хэмжээнд дахин төлөвлөлтийн 500 гаруй төсөл хэрэгжиж



байгаагийн 80 гаруй хувь нийслэл хотод хэрэгжиж байна. Өнгөрсөн 2014-2025 онд нийт 19000 орчим айлын орон сууцны барилга шинээр баригдсан боловч гэр хороолол улам тэлсээр иргэдийн амьдрах орчин, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх, байгалийн гамшигт өртөх, нийгмийн үйлчилгээ хүртэж чадахгүй байх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлага амьдралд тулгарсаар байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 1,677,872 хүн амьдарч байгаа ба хот, суурин дахь ашиглалтын шаардлага хангахгүй хуучирсан барилга байгууламжуудыг буулгаж шинээр барих, гэр хорооллыг барилгажуулах үйл ажиллагааг богино хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулах хэрэгтэй болоод байгаа юм. 2026.02.26-ны өдөр МБҮА ТББ-ын дахин төлөвлөлтийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа гишүүн байгууллагуудын төлөөллүүдэд Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг ХББОСЯ-ны захиалгаар Хот, Суурин Газрыг Дахин Хөгжүүлэх Тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа “ЭМС консалтинг” ХХК-ийн ахлах хуульч С.Энхжаргал, доктор Б.Батчимэг нар танилцуулж, төсөл хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлууд болоод цаашид хэрхэн ажиллах, хуулийн үзэл баримтлалд ямар санал тусгуулах талаар санал солилцлоо.

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСӨЛ ДЭЭР МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЛЭЭ



Нийслэлийн зүгээс 2026 оныг бизнес эрхлэгчдийг дэмжих жил болгон зарласан бөгөөд 2026.02.7-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар болон холбогдох албаныхан БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД-тэй уулзаж нийслэлийн бүтээн байгуулалтын төслүүдийг танилцуулахаас гадна салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаад байгаа зарим асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэх, гарц шийдлийг хайх, хамтран ажиллах тал дээр саналаа солилцлоо.

Уг арга хэмжээ, уулзалтад МБҮА ТББ нь Удирдах зөвлөлийн гишүүд болоод гишүүн байгууллагуудтайгаа нийслэлийн иргэдийн ая тухтай, аюулгүй, эрүүл амьдрах нөхцлийг бүрдүүлэх, барилгын зах зээлийн багтаамжийг тэлэх чиглэлээр дараах саналуудыг гаргаж албан бичгийн хамт гардуулан өглөө.

- Архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз батлах, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох үйл явцыг бүрэн цахимжуулах замаар хүний оролцоог арилгаж,
- шийдвэр гаргалтыг хурдтай, ил тод болгох – учир нь холбогдох ажлын албадын үйл ажиллагаанд хүнд суртал, техникийн болон хүнээс хамаарсан саатал их байна;
- Худалдан авах ажиллагаа буюу тендэр зарлах, үнэлэх, хэрэгжүүлэх, хүлээн авах процесс дахь төвлөрлийг арилгах – эдгээр бүх процессыг хот өөрөө төвлөрүүлэн хэрэгжүүлдэг бус сонгон шалгаруулалт, захиалагчын хяналтын үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод байгууллагуудыг оролцуулах;
- Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг дахин төлөвлөх ажлыг хувийн хэвшил болон мэргэжлийн ТББ-ууд хариуцан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны дахин төлөвлөлтийг ган нэг барилгаар бус орон сууцны хотхон хорооллоор нь дахин төлөвлөх төслийг хэрэгжүүлж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны архитектур дизайн-стандартыг алдагдуулахгүй байх өмнөх алдааг давтахгүй байх;
- Гадаадын зээл, тусламж болон бондын хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдэд дотоодын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тодорхой шалгууруар хангуулж, дэмжих бодлого баримтлах;Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн нийслэлийн хувьд газар доорх барилга байгууламжуудыг хөгжүүлэх тусгай төсөл хэрэгжүүлэх замаар иргэдийн эрүүл аюулгүй тав тухтай орчинд амьдрах нөхцлийг нэмэгдүүлж, хотын түгжрэл, ачаалал, төвлөрлийг бууруулах - МБҮА ТББ хамтран ажиллахад бэлэн байна;
- Улаанбаатар хотын суурьшлын томоохон хэсэг болоод буй Богдхан уулын тусгай хамгаалалттай газрын барилгажилтын асуудлыг шийдэрлэж, бодлогоо тодорхойлох;
- Барилгын инженерийн техникийн нөхцлийг улирал харгалзахгүй (бүтэн жилийн турш) олгодог тогтолцоонд шилжих, техникийн нөхцөл олголтыг цахимжуулах замаар аж ахуйн нэгжүүдийн бизнес төлөвлөлт үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах замаар бүтээн байгуулалтын хурдыг

- нэмэгдүүлэх;
- Улаанбаатар хотын эрчим хүчний дутагдал үүсээд буй өнөөгийн нөхцөлд Барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварт (А даалгавар) сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах техникийн нөхцөлийг тусгах, үйлдвэрлэсэн илүүдэл эрчим хүчийг төвийн сүлжээнд нийлүүлж ашиг олох тогтолцоо бүрдүүлэх замаар үүсээд буй асуудлыг шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх;
- Барилга бүтээн байгуулалтад ашигладаг том оврын автомашин, механизмыг 22 цагаас хойш хөдөлгөөнд оролцуулахаар заасан байдаг бөгөөд энэ нь хүн амын суурьшлын бүсэд 22 цагаас хойш чанга дуу чимээ гаргахыг хориглодог заалттай зөрчилдөж байгааг эргэн харж оновчтой болгох – учир нь үүнээс үүдэн оршин суугчид, барилгын байгууллагын хооронд зөрчил үүсч, барилгын ажил саатах, гацаах, удаашрах, үргэлжлэх хугацаа уртсах, ханган нийлүүлэгч байгууллагуудыг алдагдалтай ажиллах /байнга торгуулах/ нөхцөл үүсгэдгийг шийдвэрлэх шаардлагатай зэрэг олон асуудлын хүрээнд саналаа хүргүүллээ.

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСӨЛД МБҮА ТББ ХАМТРАН ОРОЛЦОХООР САНАЛ СОЛИЛЦЛОО

Нийслэлийн орон сууцны корпорацийн Гүйцэтгэх захирал М.Говьсайхан, Орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү



нартай МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан Улаанбаатар хотод хэрэгжиж буй гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүд, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах төслийн хүрээнд төр болоод төрийн бус байгууллагууд хэрхэн хамтран ажиллах боломжтой талаар 2026.01.21-ны өдөр санал солилцлоо. Нийслэлийн орон сууцны корпораци нь гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүд, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах, дэд төвүүдийг орон сууцжуулах, түрээсийн орон сууцны олон талт хэлбэрийг хөгжүүлэх гээд олон чиг үүргийг хэрэгжүүлж байгаа билээ. Тус төслүүдийг хэрэгжүүлэхэд НОСК-ийн зүгээс дэд бүтэц, техникийн зөвшөөрлийг өгөх, архитектур төлөвлөлтийн зургийг батлах, оршин суугчидтай гэрээ хэлцэл хийхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа ч иргэдийн үл зөвшилцлөөс шалтгаалж төсөл удаашрах, хугацаа алдах зэрэг бэрхшээлүүд тохиолдож байгааг дурдаж байлаа.Харин МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь Ассоциацийн гишүүн байгууллагууд нь консорциум хэлбэрээр нэгдэж ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлэхдээ нэг хоёр байшингаар нь хийж байгааг нэг гудамж, блокоор нь цогц байдлаар төсөл хэрэгжүүлэх нь үр ашигтай талаар саналаа илэрхийллээ. Нэг гудамж, блокоор нь төсөл хэрэгжүүлснээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, архитектур, дизайн, төлөвлөлтийн хувьд хотын стандартад нийцнэ, Нөгөө талаар төслийн үр ашиг, гүйцэтгэлийн хувьд үр дүнтэй, ач холбогдолтой байх юм.

Мөн орон сууцны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ мэргэжлийн холбоотой хамтран хот төлөвлөлт, төр хувийн хэвшлийг оролцуулан төслийн загварчлалыг боловсруулах, оновчтой байдлаар шийдэх, харилцан үр ашигтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх нь чухал болохыг онцоллоо.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН БАРИЛГЫН НОРМ, ДҮРЭМ СТАНДАРТЫГ ХЭРЭГЛЭХ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙГАА ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО



МБҮА ТББ нь сар бүр салбарт ямар асуудлууд тулгамдаад байгаа, түүнийг хэрхэн шийдвэрлэх, гарц, шийдэл юу байгаа талаар санал солилцох “Өглөөний уулзалт”-ыг зохин байгуулж хэвшээд байгаа билээ. 2026.06.11-ны өдрийн уулзалтаар “Барилгын салбарын сүүлийн үеийн норм, норматив, стандарт, дүрмийн шинэчлэл, зураг төслийн магадлал” сэдвийн хүрээнд БХТ-ийн ТӨҮГ-ийн Барилга байгууламжийн норм, нормативын хэлтсийн дарга Д.Алтанхуяг, Зураг төслийн магадлал зохион байгуулах хэлтсийн дарга Г.Мөнхболд нар нь төрөөс барилгын салбарын талаарх баримтлах бодлого, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив, 2026 онд батлуулахаар төлөвлөж буй томоохон нормуудын талаарх мэдээллийг танилцууллаа. Тус уулзалтад МБҮА ТББ-ын гишүүн байгууллагууд болох NCD групп ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Хүрэлхүү, Монкон групп ХХК-ийн Ерөнхий инженер Х.Чинзориг, Таван Богд пропертиз ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Агваангэлэг, Эм Жи Эл И Эн Си ХХК-ийн захирал Б.Билгүүн, Макс Өргөө ХХК-ийн Ерөнхий архитектор Н.Уянга, Монгол Улсын гавьяат барилгачин Л.Шагдаррагчаа нар оролцож Монгол Улсад мөрдөгдөж буй барилга байгууламжийн норм, нормативыг бусад улс орны жишиг рүү ойртуулах, цаг үетэйгээ нийцүүлэн хурдан өөрчлөн, шинэчлэх, норм, нормативын давхардлыг арилгах, цаашлаад барилгын үйл ажиллагаанд олон улсын барилгын норм, дүрэм стандартыг хэрэглэх эрхзүйн орчныг сайжруулах шаардлагатай байгааг онцолцгоосон юм.

УДААШРАЛТАЙ БАЙГАА ХУУЛИУДЫН ТӨСЛИЙГ ШУУРХАЙ ХЭЛЭЛЦҮҮЛЖ БАТЛУУЛАХ, БАРИЛГЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛАЛАА



МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар: ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДЭД ТӨРИЙН ОРОЛЦООГ БАГАСГАХ САНАЛЫГ БАРИЛГЫН КОМПАНИУД ТАВЬЖ БАЙНА



КОНСТРАКШН МАРКЕТ

"CONSTRUCTION MARKET 2026" ФОРУМЫН ЭРГЭН ТОЙРОНД



МБҮА ТББ нь салбартаа түүчээлж, хөрөнгө оруулж улсынхаа хөгжил цэцэглэлтэд ихээхэн хувь нэмэр оруулдаг томоохон мэргэжлийн холбоо болохын хувьд барилгын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, зураг төсөл, банк санхүүгийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа, тулгарч байгаа бэрхшээл, түүнийг хэрхэн даван гарах шийдэл, гарц гаргалааг сонсох, салбарын нэгдсэн судалгаа мэдээ, мэдээллийг хүргэх "CONSTRUCTION MARKET–2026" форумыг 2026.04.22-ны өдөр зохион байгууллаа.

Тус форумын арга хэмжээг нээж МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан:

... Энэ форумыг бид зүгээр нэг хэлэлцүүлэг биш, салбарыг чиглүүлэх манлайлагч форум болгох зорилготой. Өнөөдөр манайд форум, хэлэлцүүлэг олон байна. Гэхдээ:

- Шийдвэр гардаггүй
- Үр дүн тодорхойгүй
- Хариуцлага үлддэггүй байдал ажиглагдаж байна.Иймээс энэ форум нь
- Нэгдсэн байр суурь
- Бодлогын санал
- Хамтын шийдэл гаргах зорилготой юм.

Мөн бид энэ форумын төгсгөлд дараах бодит үр дүн гаргана.

1.Салбарын байр суурь
2.Засгийн газарт өгөх санал
3.Салбарын дотоод зорилт

Өнөөдөр бидний өмнө байгаа хамгийн том сорилт бол санхүүжилт биш, зах зээл биш — системийн асуудал болоод байна. Ялангуяа зөвшөөрлийн тогтолцоо салбарын хамгийн том bottleneck буюу гацдаг цэг болж байна.

Дэлхийн туршлага нэг зүйлийг харуулж байна:Зөвшөөрлийг хурдан болгодог зүйл нь хүн биш — систем. Энэ процессийг хүнээс биш — хугацаанаас хамаардаг автоматжуулсан систем болгосон байна. Асуудал нь хуульд биш — системд байдаг. Засгийн газрын зүгээс энэ чиглэлд шинэчлэл эхлүүлж байгаа нь бидэнд шинэ боломж юм. МБҮА энэ бодлогыг дэмжиж, хэрэгжилтэд оролцож ажиллах болно. Мөн бид нэг зүйлийг ойлгох ёстой. Өнөөдрийн барилгын салбар зөвхөн бетон, арматурын тухай ойлголт биш.

-технологи
-чанар
-стандарт зэрэг иж бүрэн инженерийн системийн нийлбэрийн тухай ойлголт юмаа.

СТАНДАРТ ГЭДЭГ БОЛ зөвхөн төрөөс тавьдаг шаардлага бишээ. Энэ бол салбар өөрөө хамтдаа тогтоож, хамтдаа мөрдөж, хамтдаа хамгаалдаг ҮНЭТ ЗҮЙЛ юм.

Эцэст нь, Бид зөвхөн ярьдаг салбар биш — хийдэг салбар байх ёстой.

Салбарын асуудлыг хамгийн сайн мэддэг нь —бид өөрсдөө. Иймээс бид зөвхөн шаардлага тавьдаг биш — шийдэл гаргаж, хэрэгжүүлдэг оролцогч байх ёстой.

Тэгвэл бид яах ёстой вэ?

Нэгдүгээрт — **АСУУДЛЫГ ЗӨВ ТОДОРХОЙЛНО.**

Гацдаг цэгүүдийг баримт, тоонд тулгуурлан нэг ойлголтод хүргэнэ.

Хоёрдугаарт — **ШИЙДЛИЙГ БОЛОВСРУУЛНА.** Асуудал бүр дээр: ямар шийдэл, ямар хугацаанд, ямар өөрчлөлт гарах гэдгийг тодорхой болгоно.

Гуравдугаарт — **ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН төлөө ажиллана.** Шийдэл зөвхөн санал биш — хэрэгждэг байх ёстой.

ЦУВРАЛ ПИ АР, СУРТАЛЧИЛГАА



























Барилгын салбарынхан маань
ногоон барилга руу шилжих
шаардлагатай байна
Ногоон барилгын шаардлага
хангасан байвал
УУР АМЬСГАЛЫН
НОГООН
САНГААС
САНХҮҮЖИЛТ
авах боломж байна.
О.БАЯРСАЙХАН
Худалдаа хөгжлийн банк-ны Олон улсын
банкны газрын захирал


Банкны секторт барилгын
салбарт чиглэсэн
НИЙТ 3.4
их наяд
ЗЭЭЛИЙН БАГЦ
байдаг.
Үүний 30%-ийг нь ХААН банк бүрдүүлдэг.
Энэ багцын 70-80% нь ногоон барилгад
чиглэдэг. Бид харилцагч төөгөө байх
хүрээнд барилгын салбарт аль болох бага
хүүтэй зээл олгох, шаардлагатай сертификат
авах чиглэлд хамтраад явж байна.
Бид боломжоороо барилгын салбарыг ногоон
болтохоор ажиллаж байна. Шаардлага
хангасан төхиолдолд ногоон зээлийн багц руу
шилжүүлж байна.
Д.АРИУНБАТ
ХААН Банкны Байгууллагын банк
хариуцсан дэд захирал


Орчин үеийн шаардлага бол ер нь
НОГООН БАРИЛГЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ
Хэрэглэгч ч ногоон барилгыг
худалдан авахыг сонирхож
байгаа учраас ногоон барилгын
санхүүжилт олгох чиглэл барьж
байна.
У.НАРАНБАЯР
Капитрон банк байгууллагын банкны
газрын захирал



Барилгын хөгжүүлэгч
компаниуд хөгжиж байна,
ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛДЭГ БОЛСОН
Хөрөнгийн зах зээл дээр бонд гаргах гэх
мэтээр төслөө бодитой хэрэгжүүлэх хөрөнгө
босгох боломж байгаа.
ТӨСЛӨӨ БОДИТОЙ
ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ БОСГОХ
боломж байгаа.
С.ГАН-ЭРДЭНЭ
Тэнгэр Капитал УЦК ХХК -ийн ТУЗ-ын дарга



ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
ТУЛГАМДАЖ БАЙГАА ГОЛ АСУУДАЛ БОЛ
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОН
ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТОО
маш сайн боловсруулагүйтэй холбоотой.
Тесвийн тооцоолол - Estimator
программаар нэг төсөөчний хийж байгаа
1979 оны сурьтай менежементийн зардал
тусгах боломжгүй, их савлагаатай төсөв.
Үүнийг анхаарч сайжруулах ёстой.
Б.БАЯРТУЛГА
Заг Инженерингийн ХХК-ийн Барилгын төсөл
хариуцсан захирал


"CONSTRUCTION MARKET 2026" ФОРУМЫН ЭРГЭН ТОЙРОНД
ЦУВРАЛ№12
M... See more
М.ЭНХБААТАР
МОНГОЛЫН БАРИЛГЫН УНДЭСНИЙ
АССОЦИАЦИ ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



"CONSTRUCTION MARKET 2026" ФОРУМЫН ЭРГЭН ТОЙРОНД
ЦУВРАЛ№7 Улаанбаатар Ассет Менежмент УЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Монсор:


"CONSTRUCTION MARKET 2026" ФОРУМЫН ЭРГЭН ТОЙРОНД
ЦУВРАЛ№9
T... See more
Н.АГВААНГЭЛЭГ
ТАВАН БОГД ХОЛДИНГС ХХК-ИЙН
БАРИЛГЫН ТӨСӨЛ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ


"CONSTRUCTION MARKET-2026" арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайдын Эдийн
Засгийн Бодлогын зөвлөлийн Ажлын албаны дарга Б.Делгөөн эдийн засгийн нөхцөл байдлын
талаарх илтгэл тавина.


ЗУРАГ ТӨСЛИЙН САЛБАРЫГ ТУШААД БАЙГАА БУХ ЗҮЙЛСИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ХЭРЭГТЭЙ БАЙНА:
ЭМ ЖИ ЭЛ И ЭН СИ ХХК -ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БИЛГҮҮН:


"CONSTRUCTION MARKET 2026" ФОРУМЫН ЭРГЭН ТОЙРОНД
Та бүхэндээ уг арга хэмжээний видеог хүргэж байна.
2:38 / 29:43


Construction Market 2026 – Оролцогчдын танилцуулга5
#Сорилт #ШИЙДЭЛ: Зөвшөөрөл-сорил-шийдэл-Асуудлаа ярилцья. Таван Богд Холдингс ХХК-
ийн Барилгын төсөл хариуцсан захирал Н.Агваангэлэг
0:04 / 2:14



🏗️🏦"CONSTRUCTION MARKET-2026" форум нь МБУА ТББ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг салбарын оролцогчдыг нэгтгэн салбарын хөгжлийн чиг хандлага, бодлогын асуу... See more



🏗️🏦CONSTRUCTION MARKET-2026 форум нь МБУА ТББ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг салбарын оролцогчдыг нэгтгэн салбарын хөгжлийн чиг хандлага, бодлогын асууд... See more



🏗️🏦"CONSTRUCTION MARKET-2026" форум нь МБУА ТББ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг салбарын оролцогчдыг нэгтгэн салбарын хөгжлийн чиг хандлага, бодлогын асу... See more



🏗️🏦"CONSTRUCTION MARKET-2026"-барилгын салбарын өнөөгийн нөхцөл байдалд бодит үнэлгээ хийж, тулгамдсан асуудал, сорилтыг тодорхойлон, бодлогын санал, шийдлийн хувилбару... See more





🎯🏗️"CONSTRUCTION MARKET 2026" ФОРУМЫН ЭРГЭН ТОЙРОНД ЦУВРАЛ№16 News.mn
📌... See more



NEWS.MN
Н.Баярсайхан: Монголын барилгын салбарын гол саад нь зах зээл нь биш систем нь | News.MN

Eagle News
April 22 ·

Нэг сэдвээр: Барилгын салбарт тулгамдаж буй асуудал, шийдэл



СЭЛБЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЭРГЭН ТОЙРОН МБҮА ТББ-ЫН ГИШҮҮД ЮУ ХИЙВ

СЭЛБЭ 20 МИНУТЫН ХОТ-ЫН ОЛОН НИЙТИЙН БҮСЭД ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ХУВИЙН ХЭВШЛИЙНХЭНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАЛАА



Сэлбэ 20 минутын хот-ын олон нийтийн бүсэд төсөл хэрэгжүүлэх сонирхолтой хувийн хэвшлийнхэнд нээлттэй сонгон шалгаруулалтыг 2026.01.16-03.02-ны 16:00 цаг хүртэл www.selbecity.mn вэб сайтаар хүлээж авахаар нээлттэй зарлаллаа. Сэлбэ хот нь нийт 158 га талбайд хэрэгжих бөгөөд 8575 айлын орон сууц, үйлчилгээ, соёл, бизнесийн цогц орчныг бүрдүүлэх хотын хөгжлийн томоохон бүтээн байгуулалт болох юм.

Сэлбэ хотын газрыг 2024 онд эрчимтэй чөлөөлж, нийт 113 блок барилгын ажлыг эхлүүлсэн. Эхний ээлжийн орон сууц 2027 оны тавдугаар сард ашиглалтад орно.


Төслөөс санал болгож байгаа эхний 15 бүсийн 12 бүс нь олон нийтийн, 3 бүс нь амины сууцаас бүрдэнэ. Олон нийтийн бүс 27.69 га талбай, амины сууцны бүс 15.17 га талбайг хамарна.

Нийслэлээс 2026 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласан ба барилгын салбарын бүтээн байгуулагчид, хөрөнгө оруулагчдаа дэмжихэд нээлттэй хамтарч ажиллахаа илэрхийллээ.

Тус төсөлд МБҮА ТББ-ын гишүүн байгууллага болох Монкон ХХК, Нутгийн буян групп ХХК нар гүйцэтгэгчээр ажиллаж байгаа бөгөөд тун удахгүй нийт Гишүүдийнхээ дунд уулзалт, арга хэмжээ зохион байгуулж тус төслийн олон нийтийн бүсэд хэрхэн хамтран ажиллах боломжийг хэлэлцэнэ.

СЭЛБЭ 20 МИНУТЫН ХОТ-ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-ТҮНШЛЭЛ-ХАМТЫН АЖИЛЛАГАА-ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МБҮА ТББ нь байгуулагдсан цагаасаа байгууллага, хамт олны нийтлэг эрх ашгийг нэгдүгээрт тавьж, гишүүдийн харилцан ойлголцол, хүндлэл, эв нэгдэл, шударга зарчим дээр тогтож ирсэн бөгөөд 2025 онд Сэлбэ дэд төвийн орон сууцны төслийн тендерт Монгол компаниуд оролцох боломжгүй нөхцөл шаардлага тавьсан байсныг Нийслэл, Улаанбаатар хотын ЗДТГ болон төслийн нэгжтэй олон удаагийн хэлцэл, уулзалт хийж улмаар Үндсэн хуулийн цэц, Төрийн гурван өндөрлөгт өргөх бичиг барьж зөвшилцлийн үр дүнд хамтран ажилласанаар манай гишүүн байгууллагууд ерөнхий гүйцэтгэгчээр шалгарч чадсан билээ.



2026 оны бүтээн байгуулалтын улирал эхэлж буйтай холбогдуулан тус төсөлд шалгарсан Монкон констракшн ХХК, Нутгийн буян ХХК, Професионалстрой ХХК-ийн төсөл хэрэгжүүлэгчид болон Девелопер, Гүйцэтгэгчид, Ханган нийлүүлэгчдийн бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, Сэлбэ хотод хэрэгжих боломжтой төсөл, хамтын ажиллагаа, түншлэл бий болох, мэдээлэл солилцох Өглөөний ажил хэрэгч уулзалтыг гишүүн байгууллагуудынхаа дунд 2026.03.25-ны өдөр зохион байгууллаа.



Уулзалтаар МБҮА ТББ-ын зүгээс Гишүүн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, тус төсөл хөтөлбөрт тавигдаж буй нөхцөл шаардлагыг хэрхэн хангах, улмаар дотоодын барилгын материалын норм дүрэм, стандартыг нэг ойлголтод хүргэх тал дээр холбогдох яам, төрийн байгууллага болоод салбарын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахад нээлттэй байна гэдгээ илэрхийллээ.

СЭЛБЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТАЛБАЙД УДИРДАХ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ХАБЭМ-ИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МБҮА ТББ нь ГБХНХЯ, НДЕГ, ХАБЭМТ, Сэлбэ 20 минутын хот корпорац ХХК-тай хамтран Сэлбэ бүтээн байгуулалтын талбайд ажиллаж буй компаниудын удирдах албан тушаалтнууд, инженер техникийн ажилтнуудад зориулан ХАБЭА-н хууль тогтоомж, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалт болон байгууллагын ХАБЭА -н чадварын мэдлэг олгож чадавхижуулах, болзошгүй осол эрсдэлээс хэрхэн сэргийлэх талаар “ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТИЙН ЦОГЦ АЯН-2026” сэдвийн хүрээнд 2026.06.17-ны өдөр сургалтыг зохион байгууллаа.


МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар: Нийслэлийнхний нүдэнд жил хүрэхгүй хугацаанд босож буй Сэлбэ хотын бүтээн байгуулалтад Монгол компаниудаа оролцуулахад МБҮА ТББ нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга, Нийслэлийн засаг дарга, Төслийн удирдлагын газар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд буюу маш олон удаагийн арга хэмжээ, уулзалт, харилцан ойлголцлын хүрээнд ажиллаж байж тендерийг 5 багц болгон хувааж байлаа. Үүний үр дүнд өнөөдөр Ерөнхий гүйцэтгэгч Монгол компаниудаас гадна маш олон туслан гүйцэтгэгчид энэ бүтээн байгуулалтад гар бие оролцож ажиллаж байна. Тиймээс энэ бүтээн байгуулалтыг хийж байх хугацаандаа салбарын ажлын онцлог, эрсдэлийн үнэлгээ, техник технологи, аюулгүй байдал нь ямар хууль, эрхзүйд нийцсэн байх ёстой юм, хөдөлмөрийн аюулгүй хэрхэн чанд сахиж ажиллах ёстой вэ гэдгийг өнөөдрийн сургалтаар мэдлэгээ баяжуулж, хэрэгжүүлж ажиллахыг хүссэн юм.

Сургалтаар ААНБ-ын ХАБЭМ-ийн үндсэн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, удирдлага, зохион байгуулалт: ХАБЭМТ-ийн УСГ-ын дарга М.Сэлэнгэ, Барилгын салбарын захиалагч, гүйцэтгэгч компанийн уялдаа холбоог ханган ажиллаж, үл тохирлын тоог бууруулах нь NCD группийн ХЭМАБ-ын инженер, сургагч багш, зөвлөх С.Сарантуяа, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг мэдээлэн бүртгүүлэх ГБХНХЯ-ны Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч А.Оюунтүлхүүр, Ажлын байрны нийгэм сэтгэл зүйн эрүүл мэндийн үйлчилгээ, хөгжлийн чиг хандлага, практик аргачлал: Судлаач, сэтгэцийн эмч Б.Хүсэлтүвшин, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль НДЕГ-ын мэргэжилтэн Д.Соёл-эрдэнэ болоод бусад мэргэжилтнүүд илтгэлүүд тавилаа.

ХАБЭА-ийн олон улсын жишиг, стратеги төлөвлөлт, анхаарах талаар суралцагчид асууж өөрсдийн ажлын байр дээр гараад байгаа кейс, баримтыг хэрхэн шийдвэрлэх, юуг ажлын талбай дээрх осол гэж үзэх, хууль

эрх зүйн хүрээнд ажилчдын аюулгүй байдлыг хэрхэн хангах, ажлын байр дээр осол эндэгдэл гаргахгүй байх тал дээр хэрхэн анхаарах зэргээр харилцан асуулт асууж, мэргэжлийн багш, мэргэжилтнүүдээс зөвлөмж, зөвлөгөө авсан ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

НДЕГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН Д.СОЁЛ-ЭРДЭНЭ:
ХУУЛИАР АЖИЛ ОЛГОГЧДОД МАШ ОЛОН ХӨНГӨЛӨЛТҮҮД ҮЗҮҮЛДЭГ БОЛСОН



NCD ГРУПП ХХКИЙН ХЭМАБ-ЫН ИНЖЕНЕР, СУРГАГЧ БАГШ, ЗӨВЛӨХ С.САРАНТУЯА:
2015-2025 ОНЫ ХУГАЦААНД 12360 ҮЛ ТОХИРОЛ БУЮУ ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛСЭН



НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК-ИЙН 3.3 БАГЦ ТӨСЛИЙН МЕНЕЖЕР Н.СУГАРСҮРЭН:
ТАЛБАЙ ДЭЭР АЖИЛЛАХ БОЛОМЖГҮЙ БОЛ ХАБЭА ДҮРМИЙН ДАГУУ ГАРГАДАГГҮЙ



МОНКОН КОНСТРАКШН ХХК-ИЙН 4.1 БАГЦЫН БАРИЛГА УГСРАЛТЫН МЕНЕЖЕР Н.СОРОНЗОНГОМБО:
ХАБЭА ДҮРМИЙГ МӨРДҮҮЛЭХЭД АЖИЛТАН НЭГ БҮРТЭЙ ТУЛЖ АЖИЛЛАДАГ



СЭЛБЭ ХОРИН МИНУТЫН ХОТ КОРПОРАЦ ХХК-ИЙН ХАБЭ-ИЙН ХЭЛТСИЙН ДАРГ А.БАТДЭЛГЭР:
БИД ОСОЛ ЗӨРЧЛИЙГ 0 БАЙЛГАХ ХҮРЭЭНД ДҮРЭМ ЖУРМЫГ ЯГШТАЛ БАРИМТЛАН АЖИЛЛАЖ БАЙНА.



ДОТООД, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХӨГЖЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХҮРЭЭНД ҮНДЭСНИЙ КОМПАНИУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ, ДАВУУ ЭРХИЙГ ҮНЭЛГЭЭНД ТУСГАХ, ОРОЛЦОХ БОЛОМЖИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛД МБҮА ТББ БХТ ТӨҮГ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО



Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын гишүүн байгууллагууд нь Монгол Улсын бүтээн байгуулалтын 60 орчим хувийг гүйцэтгэдэг үндэсний компаниудын нэгдэл төдийгүй төрийн чиг үүрэг болох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг 8 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

Монгол Улсын “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон “Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т барилга, дэд бүтцийн салбарыг дэмжих, үндэсний аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх талаар тусгайлан тусгасаны дагуу МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан БХТ ТӨҮГ-н захирал Д.Мөнхбаатар нар нь доорх арга хэмжээнүүдийн дагуу:

- Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн инженеринг, барилгын гэрээний жишиг нөхцөлийг орчуулах, нутагшуулах, хэрэглэхтэй холбоотойгоор мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, хамтарсан санаачилга
- гаргах, шаардлагатай төсвийг тусгах чиглэлээр хамтран ажиллана;
- Хөгжлийн төслүүдийн хүрээнд үндэсний компаниудын оролцоог хангах, давуу эрхийг үнэлгээнд тусгах, оролцох боломжоор хангах арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлнэ;
- Барилга, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө, эрчим хүч, худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал боловсруулах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллана;
- Инженер, техникийн мэргэжлийг олон нийтэд сурталчлах, оюутан, суралцагчдыг дэмжих, нийслэлийн хөгжлийн төслүүдэд инновац, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх санал гаргах, хэрэгжилтэд нь хамтран оролцох чиглэлээр талууд харилцан дэмжиж ажиллана хэмээн санамж бичиг байгууллаа.

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ БОЛОВСРОЛЫН ЯАМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Барилгын салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан, инженер техникийн боловсон хүчинг чадавхжуулах чиглэлээр МБҮА ТББ болон

Боловсролын чам хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг 2026.06.04-ний өдөр зурлаа.

Хамтын ажиллагааны хүрээнд:

- Барилгын салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлийн чиглэлийг тогтоох,
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хөтөлбөр боловсруулан шинэчлэхэд салбарын ур чадвартай ажилчдыг оролцуулан хамтран ажиллах;
- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшлах боловсон хүчнийг салбарын техник, технологийн шинэчлэлтэй танилцах боломжоор хангах, ААНБ-тай холбох, мэдээллээр хангах, мэргэжлийн санал, зөвлөмж өгөх;
- Суралцагчдыг барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын үйл ажиллагаатай танилцуулах, сургалт, дадлага, туршлага солилцооны үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Талууд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулахад бодлогын дэмжлэг үзүүлэх;
- Мэргэжилтэй ажилтны чадварыг хөгжүүлэх барилгын салбарын уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, барилгын салбарын мэргэшсэн ажилтаны ур чадварыг үнэлэн ангилах, зэрэг дэвийг тогтолцоог бүрдүүлэхэд хамтран ажиллах;
- Барилгын салбарын хүний нөөцийн хэрэгцээнд нийцсэн, мэргэжлийн ур чадвар сайтай төгсөгчдийг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад сургаж бэлтгэх;
- Талууд барилгын шинэ техник технологид суурилсан судалгаа, инновацын үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж, шинэ санаа, шийдлийг бодит хэрэглээнд нэвтрүүлэхэд хамтран ажиллах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь барилгын салбарын нийтлэг эрх ашгийг хамгаалах, салбарын хөгжлийг дэмжих, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, чадавхжуулах чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд энэхүү хамтын ажиллагаа нь барилгын салбарын боловсон хүчний тогтвортой нийлүүлэлтийг хангах, мэргэжлийн боловсролын чанарыг сайжруулахад бодит хувь нэмэр оруулах юм. Энэхүү санамж бичиг нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнтэй загварыг бий болгож, Монгол Улсын барилгын салбарын ирээдүйн хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болж байна.

БАРИЛГЫН САЛБАРЫН ХАБЭА-ЫН СУРГАЛТ, ОСОЛ ЭНДЭГДЭЛ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР МБҮА ТББ НЬ ХАБЭМ-ИЙН ТӨВТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО



МБҮА ТББ нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтран барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын тогтолцоог бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах,

сургалтын дэд бүтцийг хөгжүүлэх, барилгын салбарын ажилчдын мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн өнөөгийн нөхцөл байдал, шалтгаан, зонхилж буй өвчлөлийн талаар тодорхойлох судалгааг хийж, статистик, тоон мэдээллийг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Олон улсын төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн бодлого, техникийн зохицуулалт, стандартын орчныг боловсронгуй болгох хүрээнд хамтран ажиллахаар боллоо.

Уг арга хэмжээг 2026.04.08-ны өдөр зохион байгуулж ХАБЭМТ-ийн дарга Д.Нарансүх, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар нар гарын үсэг зурж албажууллаа.

МБҮА ТББ нь барилгын салбарын ХАБЭ сургалт хийх үүргийг хүлээн ажилладаг бөгөөд уг хамтын ажиллагааг эхлүүлснээр салбарын ХАБЭ-ийн сургалтыг тогтмол хийж, барилгын ажилчдын эрүүл мэнд, ажиллах орчны нөхцөл байдал, ажлын байрны осол эндэгдлийг бууруулах нөхцөл бий болох юм

МБҮА ТББ БАРИЛГЫН КОМПАНИУДЫГ ЭРЭМБЭЛЭХ СУДАЛГААГ ЭС АЙ СИ ЭЙ (SICA) ХХК-ТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛНЭ



МБҮА ТББ нь салбарын тендер сонгон шалгаруулалт, зөвшөөрлийн тогтолцоо, төслийн удирдлага, үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, түүнд тулгарч буй сорилтуудын өмнө төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, бодлогын шинэчлэлийг дэмжих, хамтын дуу хоолойгоо нэгтгэн хүргэх манлайллын индэр болдог байгууллага бөгөөд энэ жил барилгын салбарын 100 жилийн ой тохиож буйтай холбогдуулан дэлхийн болон бусад улс орнуудын барилгын компаниудын ангилал, эрэмбэ тогтоож байгаа туршлагаас судалж, барилгын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг ангилах, зэрэглэл тогтоох суурь мэдээллийг бүрдүүлэх судалгааны чиглэлээр ЭС АЙ СИ ЭЙ (SICA) ХХК-тай хамтран ажиллахаар боллоо.

Бусад улс орнуудын болон олон улсын туршлагаас харахад барилгын компаниудыг эрэмблэхийн тулд санхүүгийн тогтвортой байдал, төслийн туршлага, туршлага, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, аюулгүй байдлын үзүүлэлт, ажлын чанар, цаг тухайд нь төслийг дуусгах, өрсөлдөхүйц үнэ, компанийн нэр хүнд, лиценз, гэрчилгээ, манлайлагч багийн ур чадвар, нийгмийн хариуцлага зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан үздэг байна.

Энэхүү судалгааг ЭС АЙ СИ ЭЙ (SICA) ХХК бие даасан, хараат бус зарчмаар хийх бөгөөд тус компани нь эдийн засаг, нийгмийн бүхий л салбар, чиглэлд нийт 200 гаруй байгууллагын 390 орчим зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн, “Судалгаатай үндэстэн стратегийг” санаачлан хэрэгжүүлэгч судалгаа, зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага юм.

Энэхүү судалгааг хийснээр барилгын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг хөгжүүлэгч, барилга угсралт, инженерийн шугам сүлжээ, зураг төсөл, материал үйлдвэрлэгч гэх зэрэг ангиллаар зэрэглэл тогтоох боломж бүрдэх ба энэ нь барилгын зах зээл дэх шударга өрсөлдөөн, инноваци нэвтрүүлэлтийг дэмжих, захиалагч, хэрэглэгчид зөв компанийг сонгон гэрээлэх, барилгын

хөгжүүлэгч компаниуд туслан гүйцэтгэгчээ зөв сонгох, хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалт болон салбарын хөгжилд чиглэсэн бодлого боловсруулалтад дэмжлэг үзүүлэх цаашлаад тендэр сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ч эерэг нөлөөлөл үзүүлэх юм

БАРИЛГЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ЗОРИЛГООР ХБНГУ-ЫН КОМПАНИТАЙ МБҮА ТББ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО



Барилгын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, давтан сургах, тогтвортой үр өгөөжтэй ажилуулах нь салбарын хувьд нэн тэргүүний ажил болоод байгаа бөгөөд энэ хүрээнд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар нь ХБНГУ-ын Төвд агентурын захирал Т.Болдгэрэл, Гүйцэтгэх захирал Л.Одбаяр нарыг хүлээн авч уулзаж санал солилцлоо. Уулзалтаар хоёр байгууллага урт хугацааны тасралтгүй, үр өгөөжтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор:

- Барилгын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, захиалагч, гүйцэтгэгчийн гэрээний биелэлтийн хяналт тавьж байгаа туршлага судлах
- ФИДИК-ийн гэрээний сургалт зохион байгуулах, гадны сургагч багш нарыг оролцуулах
- Барилга, дэд бүтцийн арбитрын чиглэлээр ХБНГУ, Шингений орнуудын туршлага судлах
- Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар ХБНГУ, Шингений орнуудын туршлага судлах, сайн туршлагыг нутагшуулах
- Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх, олон улсын форум, үзэсгэлэн, экспо, танилцах аялалд оролцох, хамтран ажиллахаар тогтлоо.

ХБНГУ-ын Төвд агентур нь 2008 оноос хойш Монгол хүний хөгжилд зориулсан олон төрлийн үйл ажиллагаа буюу Монголын аж ахуйн нэгжүүдийг дэмжих, өрсөлдөх чадвартай боловсон хүчинг бэлтгэх зорилготой байгууллага юм.

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ СОНИРХОЛОО ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН БАРИЛГЫН САЛБАРЫНХАН УЛАМЖИЛЛАА



70 гаруй улсын, бүс нутгийн 3500 төлөөлөгчид болох 60 төрийн өндөр тушаалтан, 26 улсын сайд, дэд сайд, хамтарсан төлөвлөгөөнд нэгдсэн 13 мэргэжлийн холбооны төлөөллүүдийг оролцуулсан олон улсын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, барилгын форумыг БНХАУ-ын Олон улсын Гэрээлэгчдийн Ассоциациас (CHINCA) жил бүр уламжлал болгон Худалдааны яам (MOFCOM)-тай хамтран зохион байгуулдаг бөгөөд 2026 онд “НОГООН, ДИЖИТАЛ ДЭД БҮТЦИЙН УЯЛДАА ХОЛБООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”



сэдвийн хүрээнд Макаод өргөн хүрээнд хийлээ. Тус форумын үеэр 250 гаруй сэдэвчилсэн болон дагалдах арга хэмжээг зохион байгуулж 8000 м2 талбайд барилга бүтээн байгуулалт, дэд бүтцийн салбарт хэрэглэж байгаа хамгийн сүүлийн үеийн техник технологийн шийдэл, бүтээгдэхүүнийг танилцуулах үзэсгэлэнг зохион байгуулж байсан нь олон улс орны төлөөллүүдийн сонирхлыг хамгийн ихээр татаж байлаа.

Форумын үйл ажиллагаа 5 хэлээр синхрон орчуулгатай буюу мандарин, англи португал, испани, франц хэлээр тавигдсан бөгөөд Монгол Улсаас МБҮА ТББ-ын гадаад харилцааны менежер Б.Саранчимэг англи хэл дээр илтгэл тавьж улмаар

Байнгын хамтын ажиллагааны дижитал платформ байгуулах

Ногоон болон дижитал шийдэлд чиглэсэн дэд бүтцийн инновацын хамтарсан сүлжээг эхлүүлэх

Тогтвортой дэд бүтцийн санхүүжилтийн чиглэлээр илүү нягт хамтын ажиллагааг дэмжих

Хүний нөөцийн хөгжлийг хамтын ажиллагааны гол тулгуур чиглэл болгох саналыг дэвшүүлсэн бөгөөд арга хэмжээний үеэр Монгол Улсын барилгын салбарынхантай холбоо тогтоох, хамтрах хүсэлтээ илэрхийллээ.

Тус арга хэмжээний үеэр CHINCA-ийн Ерөнхийлөгч Фан Чючэнь Монголын МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайханд онцгойлон мэндчилгээ хүргэж хоёр улсын болоод Зүүн өмнөд азийн мэргэжлийн холбоодтой хамтран ажиллахад үлэмж хэмжээний зүтгэл гаргасныг онцгойлон дурдсан юм.

МБҮА ТББ нь уг арга хэмжээнд жил бүр VIP төлөөлөгчөөр уригдаж оролцдог бөгөөд урд өмнөх жилүүдэд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Удирдах зөвлөлийн гишүүн Б.Баасансүрэн нар оролцож хамтын ажиллагаагаа бэхжүүлэх тал дээр манлайлан оролцож ажиллаж байсан билээ. МБҮА ТББ нь дэлхийн 20 мэргэжлийн холбоотой нэгдэн хамтарсан төлөвлөгөөг баталсан бөгөөд өнгөрсөн 2025 оны 9-р сард БНХАУ-ын Олон улсын Гэрээлэгчдийн Ассоциациас (CHINCA) -тай хамтран CHINCA&MNCA үзэсгэлэн, формын хамтарсан арга хэмжээг Монгол Улсад зохион байгуулж байсан билээ.

ОЛОН УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БАРИЛГЫН ФОРУМ, ҮЗЭСГЭЛЭН (IIICF)-Д **Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ** ОРОЛЦОЖ БАЙНА



БНХАУ-ын Олон улсын Гэрээлэгчдийн Ассоциаци (CHINCA) нь Олон улсын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, барилгын форумыг (IIICF) өөрийн улсын Худалдааны яам (MOFCOM), Гадаад хэргийн яам (MOFA), Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо (NDRC), Төрийн өмчийн хяналт, удирдлагын хороо (SASAC), Хонконг, Макаогийн асуудал эрхэлсэн газар (HMO),

Макаогийн засаг захиргааны тусгай бүс болон Төв Засгийн газрын Макао дахь Холбооны Төлөөлөгчийн Газруудтай (LOCPG MO) хамтран зохион байгуулдаг бөгөөд уг арга хэмжээнд Монгол Улсаас Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-иас Гадаад хамтын ажиллагаа хариуцсан менежер Б.Саранчимэг оролцож байна.

Олон улсын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын сэдвийн хүрээнд зохион байгуулагддаг олон улсын форумд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь Монгол улсын барилга бүтээн байгуулалтын өнөөгийн байдал болоод хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн танилцуулгыг хийж байна.

“НОГООН, ДИЖИТАЛ ДЭД БҮТЦИЙН УЯЛДАА ХОЛБООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” сэдвийн хүрээнд 2026.06.10–12-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байгаа уг арга хэмжээний үеэр барилга, дэд бүтэцэд хэрэгжиж байгаа хамгийн сүүлийн үеийн шинэ дэвшилтэт техник технологи, арга хэрэгсэл, программ хангамжийн үзэсгэлэн зохион байгуулагдаж байна.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь Азийн ба Баруун номхон далайн орнуудын Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн Удирдах зөвлөлийн гишүүний хувьд Хятадын Олон улсын Гэрээлэгчдийн Ассоциаци (CHINCA)-иас зохион байгуулдаг тус арга хэмжээнд жил бүр оролцдог бөгөөд уг арга хэмжээнд Азийн орнуудын төрийн өндөр албан тушаалтнууд, шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, олон улсын төслийн хөрөнгө оруулагчид, гүйцэтгэгчид, “Fortune Global 500”-д багтдаг дэлхийн бизнесмэнүүд хуран чуулж, хамтран ажиллах боломжийг олгодог томоохон платформ юм.

3 УЛСЫН СУРГАЛТ, ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛД **Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ**-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨЛӨӨЛЛҮҮД ОРОЛЦЛОО



ПАССИВ ХАУС - УХААЛАГ БАРИЛГА - БАРИЛГЫН МЕНЕЖМЕНТ

“Passive house - Smart build – facility management”

Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг хөгжүүлэх, хэрэгжүүлэх замаар тэр дундаа барилгын салбарын эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгох, түүний зохист ашиглалтыг бий болгох ухаалаг технологи, шийдлүүд нь уур амьсгалын хамгаалал, төвлөрлийг сааруулахаар нэгдэн ажиллах нь анхаарлын төв болоод байна.

Тэр дундаа Европын холбооны орнуудад үүнийг хэрхэн нэгдэн ажиллаж буй бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх туршлага судлах мөн “Пассив хаус - ухаалаг барилга - барилгын менежмент” сэдэвт сургалт аялалыг 2026.04.27-05.04-ны өдрүүдэд:

🇩🇪ХБНГУ

🇦🇹Чех Улс

🇨🇿Австри Улс

Нийт 3 улсын 8 хотоор 2510км-ийн аялалыг (ХБНГУ-ын Франкфурт хотоос эхлэн) зохион байгууллаа. Тус аялалд хамрагдсанаар дараах сургалт, туршлагыг судлахаас гадна Европын улс орнуудын барилгын салбарт баримталж буй бодлого, цаашдын чиг



хандлага өнөөгийн байдалтай танилцсан юм.

СУРГАЛТ:

Барилгын салбарт тэргүүлж буй арга, туршлагаас суралцах,

Ногоон хөгжлийн зорилго, зорилтуудад нийцсэн хот, барилгын бүтээн байгуулалтын арга зам, туршлага судлах,

Нөөцийн хэмнэлт бүхий дэвшилтэт цахим технологуудтай танилцах, суралцах

Үйлдвэрлэл үйлчилгээний бүтээмж дээшлүүлэх арга замуудаас суралцах,

Үндэсний бөгөөд олон улсад өрсөлдөх чадварыг өсгөх арга замуудад суралцах

Бидний аялалын дэлгэрэнгүй товч тэмдэглэл: **https://shorturl.at/KAk3P**

МБҮА ТББ БНТУ-ЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦЛОО



БНТУ-д жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “TURKEY BUILD-2026” барилга, барилгын материал, шинэ дэвшилтэт техник технологийн үзэсгэлэн яармаг 2026.04.26-29-ны өдрүүдэд болж өнгөрлөө. Уг арга хэмжээнд МБҮА ТББ нь гишүүн байгууллагуудаа туршлага судлуулах, сургалт арга хэмжээнд хамруулах, хамтын ажиллагааны боломж бололцоог эрэлхийлэх хүрээнд тогтмол оролцож ирсэн билээ.

2025 онд МБҮА ТББ нь тус улсын Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбоотой хамтран ажиллахаар болсон бөгөөд тус холбоо нь 1984 онд үүсэн байгуулагдсан ба дотроо хаалганы, цонхны, материал үйлдвэрлэгчдийн, сангийн, дээврийн гээд тус тусын чиглэл бүхий олон холбоодуудын нэгдэл юм байна.



Уг хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсад урт удаан хугацаанд хэрэгжих төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй компани, аж ахуйн нэгжүүдэд барилгын бараа материалын чанар, өнгө үзэмж, хэлбэр хэмжээ, үнийн сонголтуудыг тусгайлан гаргаж өгч хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

Дээрх үзэсгэлэн нь барилгын материалын дээврийн, дулаалгын, хавтан үйлдвэрлэл, фасад, угсралт, хэв хашмал, тулаас төмөр, тавилга, хаалга, барилгын багаж хэрэгслийн хамгийн сүүлийн үеийн шийдэл, технологийн дэвшлийг сурталчлах, танилцуулах төрлөөр дагнасан бөгөөд дээрх бизнес эрхэлдэг аж ахуй нэгжүүдэд шинэ харилцагчтай болох, бизнесээ төрөлжүүлэхэд боломжтой аж.

САЛБАРЫН СУДАЛГАА:



МБҮА ТББ нь 2026 оноос барилгын салбарт үүсээд буй барилга угсралтын ажлыг эхлүүлэх болон үргэлжлүүлэх зөвшөөрөл гэж юу вэ, барилга угсралтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл, хот төлөвлөлт, бүсчлэл, аюулгүй байдал, байгаль орчин болон техникийн холбогдох дүрэм, журам, норм норматив, хяналт, аюулгүй байдлын шаардлага, хяналт шалгалт, зохицуулалтын тогтолцоо, улс орнуудын тусгай зөвшөөрөл олголтын байдал, орон сууцны үнэ ханшид юу нөлөөлж, ажиллах хүчний хомсдол, тендер, худалдан авалт зэрэг бүхий л төрөл зүйлийн судалгааг хийж байгаа билээ.

Уг ажлын хүрээнд сар бүх тогтмол контент хийдэг болсон бөгөөд 2026.01-06-р сард 7 цуврал судалгааг хийж та бүхэндээ өргөн бариад байна.



МБҮА

ГИШҮҮНЧЛЭЛ, МАРКЕТИНГ

Судалгааны чиглэлээр



ГИШҮҮДЭЭ СОНСЪЁ

2026.01-р сар

ГИШҮҮДЭЭ НЭМЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилт, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан ажлын хүрээнд 2026.01-06-р сарын хооронд “Гишүүдээ сонсъё” уриан доор дараах ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. Үүнд:

- Гишүүнчлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан хүргэхээр мэдээлэл постер бэлтгэн холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2026.01-06-р сард12 компанийг гишүүнээр элслээ.

Гишүүн байгууллагуудын захирлуудтай уулзаж санаа бодлын сонсох, уулзалтаас гарсан санал, зөвлөмжийг төлөвлөгөөт ажилдаа тусган ажиллах зорилгоор УУЛЗАЛТЫН ХУВИАР гарган дараах гишүүн байгууллагуудтай уулзан ажиллахыг зэрэгцээ мөн, дараах асуулга, судалгаа, хуудсыг шинэчлэн авах зорилгоор уулзав.



Үүнд:

-Гишүүнчлэлийн бүртгэлийн хуудас

-Сэтгэл ханамжийн судалгаа-2025

-Төрийн дээд одон медаль, цол тэмдгээр шагналаар тодорхойлох хүсэлтийн судалгаа зэрэг багтсан болно.

Уг нөлөөлөл, идэвхжүүлэлтийн хүрээнд нийт 28 гишүүн байгууллагуудаар зочилж, уулзаж, ярилцаж, саналыг тусгасанаар үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд саналыг тусган ажиллалаа.



МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨЛӨӨЛЛҮҮД ТӨРИЙН ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДЛАА



Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой энэ онд тохиож байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх салбарын төлөөллүүдтэй уулзаж ойн баярын мэндчилгээ дэвшүүлэхээс гадна өнгөрсөн хугацаанд үр бүтээлтэй ажилласан хүмүүст төрийн одон медаль гардууллаа.

Улс эх орны эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад өндөр нөлөө үзүүлдэг барилгын салбарынхан өнгөрсөн 2025 онд барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 11.7 их наяд төгрөгт хүрч, ДНБ-ийн 3.5 орчим хувийг бүрдүүлж, 100 мянга гаруй ажлын байрыг бий болгосон бөгөөд энэ өсөлтөд МБҮА ТББ болоод түүний Гишүүн байгууллагууд тодорхой үүрэг гүйцэтгэсэн билээ.

Тийм ч учраас МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагууд болох:

-Хөдөлмөрийн гавьяаны улааны тугийн одон-Цаст констракшн ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Баярцэцэг

Алтан гадас- Хьёндэ Элеватор Монгол ХХК-ийн Ерөнхий захирал Ч.Хишигбаатар

Алтан гадас -Бармон ХХК-ийн инженер Д.Ганбаатар

Алтан гадас-Бармон ХХК-ийн инженер Ж.Батсүх

Алтан гадас MSC пропертис ХХК-ийн инженжер Г.Ариунаа

Алтан гадас Заг ХХК-ийн инженер н. Оюунбат

Хөдөлмөрийн хүндэт медаль-УГГО ХХК-ийн захирал Т.Ууганбаяр нар шагнагдлаа.

Тус уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих зорилгоор “Ногоон нуур-1008” айлын орон сууцны төсөл болон “Солонго 1,2” орлогод нийцсэн орон сууцны 5002 айлын төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн бол Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах чиглэлээр Мянганы сорилтын хоёр дахь компакт гэрээг байгуулж, Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэр, ус гүн цэвэршүүлэх болон хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрүүд, мөн БНХАУ-ын зээлээр Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг барих ажлуудыг эхлүүлж, энэ жилээс ашиглалтад орж эхлээд байна.



Мөн хууль эрх зүйн томоохон шинэчлэлийн хүрээнд Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Орон сууцжуулалтын тухай, Орон сууцжуулалтын төрөлжсөн банкны анхдагч хуулиудын төсөл бүхий барилгын салбарын багц хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэх гэж байгаа тухай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан танилцууллаа.

СУРГАЛТ АРГА ХЭМЖЭЭ

ФИДИКИЙН НЭР ТОМЬЁО ГАРЫН АВЛАГЫГ АНХ УДАА ХЭВЛҮҮЛЭН СУРГАЛТАД ХАМРАГДСАН ОРОЛЦОГЧИДДОО ГАРДУУЛЛАА



Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо ФИДИК-ийн Түншлэгч гишүүн МБҮА ТББ нь ФИДИК-ийг Монгол Улсад төлөөлөн барилга, хот байгуулалтын салбарт гэрээг хэрэгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, сурган чадавхжуулах ажлыг зохион байгуулж, салбарын үйл ажиллагаанд оролцогч хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч нарын хоорондын харилцааг зохицуулж, эрх тэгш байдлыг хангаж, хамгаалан ажиллах үүргийн хүрээнд 2026.05.28-ны өдөр ээлжит сургалтаа зохион байгуулж байгаа МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар онцолсон юм.

Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбооноос эрхлэн гаргадаг ФИДИК-ийн саарал номны нэр томъёоны тодорхойлолтыг барилга, авто зам, дэд бүтцийн салбарынхандаа зориулан тэмдэглэлийн дэвтэр хэлбэрээр хэвлэн тараах байгаа бөгөөд Дэлхийн банк болоод Азийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжиж байгаа төслүүд бүгд ФИДИК-ийн гэрээний зарчмаар хэрэгжиж байгаа билээ.

Тус гэрээний дагуу төсөл хөтөлбөр хэрэгжих нь бүтээн байгуулалтын чанар сайжрах, хугацааг хянах, төслийн өртөг, үнэ нэмэгдэхгүй байх, оролцогч талуудын эрхийг тэгш хангах зэрэг олон давуу талуудтай төдийгүй Дэлхийн ихэнх улс оронд төслийн зөвлөх, ерөнхий гүйцэтгэгчтэй нэг хэлээр ярих үндсэн суурь тавигдах нөхцөл бүрдэж байгаа юм.

Өнөөдрийн сургалтыг МБҮА ТББ-ын дэргэдэх Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын ЕНБ-ийн дарга, хуульч Э.Төгстөгөлдөр удирдан, Легал Линк Эм Эн ХХК-ийн хуульч Ж.Цолмон, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын Арбиртын Арбитрч Б.Батсэлэнгэ нар ФИДИК-ийн жишиг гэрээний ялгаа, хэрхэн сонгох, өргөн хэрэглэгддэг улаан, шар мөнгөлөг гэрээнүүдийн онцлог, талуудын эрх үүргийн харилцааг бодит кейс, туршлагууд, хийгдсэн гэрээнүүд дээр тайлбарлан танилцууллаа.

Монгол Улсад Фидик-ийн гэрээг түгээн дэлгэрүүлэхэд гүн туслалцаа үзүүлж тус нэр томъёоны тодорхойлолт бүхий тэмдэглэлийн дэвтрийг бүтээхэд оролцсон МБҮА ТББ, Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ, -ын нэр бүхий хуульч, эдийн засагч, инженерүүд, зөвлөхүүддээ гүн талархал илэрхийлье.



Уг дэвтэр нь өдөр тутмын үйл ажиллагаа, гэрээ эрх зүй боловсруулах, хийх явцад гарын дор байх төдийгүй бичиж тэмдэглэдэг хуудастай хийснээр инженерүүдэд ажлаа хийх, өөрийгөө боловсруулах бэлэн гарын авлага болж байгаагаараа онцлог юм.

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ НОГООН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГ ХАНДЛАГА” ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО БҮХИЙ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Эрчим хүчний хэмнэлттэй ногоон төлөвлөлтийн чиг хандлага” сургалтыг ХББОСЯам, БХТ ТӨҮГ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо ТББ,



Монголын Ногоон Барилгын хүрээлэн ТББ нар хамтран 2026.01.27-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтыг ХБХОСЯ-ны Хэлтсийн дарга Д.Батзориг барилгын салбарын ногоон эдийн засгийн шилжилт, төр засгийн бодлогын талаар нээж үг хэлсэн бөгөөд УИХ-ын гишүүн Г.Лувсанжамцын зөвлөх Н.Нарантуяа Ногоон санхүүжилтын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 57-р тогтоолын талаар, МНБХ ТББ-ын УЗГ Б.Батжав “Шанхай хотын Ногоон барилгын инженерийн зураг төслийн баримт бичгийн Гүнзгийрүүлэлтийн журам”, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал, төслийн удирдагч М.Энхбаатар “Дулаан шийдэл II” төслийн хэрэгжилт, үр өгөөж, BIPV Mongolia ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Болорбайгаль “Эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны эдийн засгийн үр өгөөж”, Орон сууцны В стандарт авсан туршлагаасаа “Амгалан резидэнс” хотхоны Үйл ажиллагаа эрхэлсэн захирал н.Эрдэнэпүрэв нар салбарын инженер техникийн ажилтнууд, захирлуудад танилцуулга хийлээ.



Мөн сургалт, арга хэмжээнд хүрэлцэн ирсэн инженерүүдэд Монголын Барилгын Инженерүүдийн Холбооноос барилгын салбарын мэргэжил дээшлүүлэх сонгон суралцах нэг багц цагийн гэрчилгээг гардууллаа.

ТЕНДЕРТ ХЭРХЭН БЭЛДЭХ, ОРОЛЦОХ ТАЛААРХ СУРГАЛТЫГ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДДАА ХИЙЛЭЭ



Монгол Улсын хувьд томоохон бүтээн байгуулалтын ажлууд тасралтгүй өрнөж байгаа энэ цаг үед аж ахуйн нэгжүүдийн хувьд зарлагдаж байгаа тендерт хэрхэн оролцох, ямар шалгуур нөхцлийг хангасан байх ёстой, ямар бэлтгэл ажлыг хийх вэ гэдэгт мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөх үүднээс МБҮА ТББ нь Сайн худалдан авалтын зөвлөх НҮТББ-тай хамтран Тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулалт сэдэвт сургалтыг 2026.02.11-ны өдөр гишүүн байгууллагуудынхаа хүрээнд зохион байгууллаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар Монгол Улсын хэмжээнд зарлагдаж буй бүх тендер тухайн жилийнхээ 5 сард зарлагдаж дуусдаг бөгөөд энэ хугацаанаас өмнө аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн оролцохоор сонирхож буй тендерт оролцдог билээ. Нийслэлийн хувьд энэ жил 04.15-ны өдрөөс өмнө бүх тендерүүдээ зарлаж дуусахаа мэдэгдсэн бөгөөд уг хугацааны өмнө нийслэлээс зарлагдаж буй тендерүүдэд ч оролцох боломжийг хангах үүднээс худалдан авах ажиллагааны мэдлэгийг бэхжүүлэх, практик зөвлөгөө, мэдээлэл, хууль эрх зүйн өөрчлөлт,

тендерийн өгөгдлийн хүснэгт дээр хэрхэн ажиллах, техникийн тодорхойлолт, тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт,

гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, гомдол гаргах, хянан шийдвэрлэх процесс, тендер шалгаруулалт зохион байгуулахад анхаарах асуудлын талаар тодорхой мэдээллийг хүргэлээ.

"БАРИЛГЫН ТӨСӨВ, ҮНЭ БҮРДЭЛТ" СУРГАЛТЫГ ДАРХАН-УУЛ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй, МБҮА ТББ-ын хамтран хэрэгжүүлдэг "Дулаан шийдэл II" төсөл нь Барилгын төсөвчдийн холбоо ТББ-тай хамтран “Барилгын төсөв, үнэ бүрдэлт” сургалтыг 2026.03.13-нд Дархан-Уул аймагт зохион байгууллаа.

Энэхүү сургалтыг барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах багц хөтөлбөрийн хүрээнд, тэдгээрийн санал хүсэлт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан, барилгын улирлыг угтан зохион байгуулж байгаагаараа онцлог юм.

Сургалтыг МБҮА ТББ-ын Дархан-Уул салбарын тэргүүн С.Дэлгэрбаяр: “Энэхүү сургалтыг барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, тэдгээрийн санал хүсэлт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан зохион байгуулж байгаагаараа онцлог” гэдгийг дурдлаа.

Барилгын Төсөвчдийн Холбооны Тэргүүн Ү.Банди сургалтыг удирдан явуулж, барилгын төсөв гаргахдаа шинжлэх ухааны үндэслэл, тодорхой арга аргачлалд суурилж, үнэн зөв, бодитой тооцоолох нь зүйтэй. Ингэхэд барилгын төсөвчнөөс мэргэжлийн ур чадвар, уйгагүй хөдөлмөр, зөв хандлага, ёс зүйтэй байхыг шаарддаг талаар оролцогчдод зөвлөлөө.

Мөн сургалтаар төсвийн нормын бүтэц агуулга, бусад үнэ тарифыг хэрэглэх, Төсөвчний үүрэг хариуцлага, анхаарах асуудлууд, Төсөв зохиох ерөнхий дараалал, төсвийн тооцооны зарчим, Барилгын ажлын тарифт цалин, машин цагийн үнэ, материалын үнийн сонголтын талаар онцоллоо.

Түүнээс гадна барилгын төсөв, үнэ бүрдэлтийн чиглэлээр мэргэшиж буй, мэргэшихийг зорьж байгаа инженерүүд нь барилгын ажил гүйцэтгэх технологи, угсралтын стандарт зэргийг зайлшгүй мэдэж байх шаардлагатай. Аливаа барилга байгууламжийн төсвийг зөв тооцоолохын тулд анхнаасаа зурагтайгаа сайтар ажиллах хэрэгтэй. Учир нь тухайн барилгын чанар, ашиглалтад оруулах хугацаа, бүтээмж зэрэг нь төсвөөс шууд хамааралтай байдгийг нэмж мэдээлэв.

Арга хэмжээнд хүрэлцэн ирсэн салбарынханд Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын албанаас Дархан-УУл аймгийн 2026 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон тухайн онд хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөв хөтөлбөрүүдийг танилцууллаа.

Мөн Дархан төмөрлөг ХХК-ийн зүгээс үйл ажиллагааны танилцуулгаа хийгээд бүтээн байгуулалтын улирал эхэлж буйтай холбогдуулан барилгын салбарынханд зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргасанаа танилцууллаа.

БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМИЙН ШУГАМ ХООЛОЙН ҮНЭР БОЛОН ДУУ ЧИМЭЭГ БУУРУУЛАХ ШИЙДЛИЙГ ДИНАМИК ТАУЭР ХХК МОНГОЛД НУТАГШУУЛЖ БАЙНА



МБҮА ТББ-ЫН Удирдах зөвлөлийн гишүүн, Динамик Тауэр ХХК нь барилгын бохир ус зайлуулах системийн хамгийн тулгамдсан асуудал болох дуу чимээ болон таагүй үнэрийг шийдвэрлэх дэлхийн шилдэг технологийг Монгол Улсад нутагшуулахаар салбарын эрдэмтэд, зөвлөхүүдтэй хамтран танилцуулах, сурталчлах, сургах тал дээр ажиллаж байгаа бөгөөд 2026.03.26-ны өдөр ШУТИС-ийн хурлын зааланд зохион байгууллаа.

Сургалтаар бохир ус зайлуулах системийн шугам хоолойн үнэр болон дуу чимээг бууруулах шийдэл бол технологиуд болох:

Alexis & DBlue: Шугам хоолойн дуу чимээг бууруулах иж бүрэн систем.

Studor: Бохир ус зайлуулах системийн идэвхтэй агааржуулалт, үнэргүйжүүлэх ухаалаг шийдлийн талаар ухаалаг хуванцар хоолойн системийн дэлхийн тэргүүлэгч, ус, эрчим хүчний менежментэд тогтвортой шийдлүүдийг төвлөрүүлдэг Aliaxis-ийн мэргэжилтэн Daniel Rath бодит туршлага болоод судалгааны талаар танилцууллаа.

Дээрх технологи нь барилгын салбарт дэвшилтэт шийдэл, ажиллах хүч, материалын зардлыг хэмнэхээс гадна байгаль орчинд гайхалтай нөлөө үзүүлж байгаагаараа дэлхийд гайхагдаад байгаа талаар тус сургалтад илтгэл тавьсан Daniel Rath болон Динамик тауэр ХХК-ийн захирал Ч.Эрдэнэтунгалаг нар онцолсон юм.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МБҮА ТББ нь ОБЕГ болон Удирдах зөвлөлийн гишүүн, Баганат Өргөө ХХК-тай хамтран “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын зохицуулалт, урьдчилан сэргийлэх нь” сургалтыг нийт гишүүн байгууллагуудын дунд 2026.04.06-ны өдөр зохион байгууллаа.

Сүүлийн жилүүдэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын санамсар болгоомжгүйн үүднээс барилга байгууламж гал түймэрт өртөж иргэдийн амь нас, эд хөрөнгийн үлэмж хэмжээний хохирол тасралтгүй гарч байгааг та бүхэн бэлхэнээ харж байна.

Иймд барилгыг анхнаасаа барихдаа онцой төвөгшилтэй болон Бага дунд өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төслийг анхнаас нь норм дүрмийн дагуу зурж, ашиглалтад өгөхдөө стандартыг барьж чадвал аливаа эрсдлээс урьдчилан сэргийлж болох ба Монгол Улсын Засгийн газрын 2025.12.17-н өдрийн 211 дүгээр тогтоолоор барилга байгууламжийн зураг төсөл болосруулах, магадлал хийх дүрмээр зохиогчийн үүрэг, хариуцлага илүү их нэмэгдэж байгаа гэдгийг гэдгийг ОБЕГ-ын ГТТГ-ын гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа Б.Мягмаржав илтгэлтдээ дурдлаа.

Мөн ОБЕГ-ын ГТТГ-ын гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч Х.Цэнд-Очир өнөөдөр мөрдөгдөж байгаа Галын аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчны мэдээллийг хүрэлцэн ирсэн барилгын компаниудад танилцууллаа.

БҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар нь “Барилга угсралтын улирал эхэлж байгаа цаг үед гишүүн компаниудынхаа дунд барилга байгууламжийн галын аюулгүй байдлаас хэрхэн урьдчилан сэргийлэх, яаж зөв төлөвлөх, өдөр тутмын ажилдаа хэрхэн анхаарал сэрэмжтэй байх талаар хууль эрх зүйн болоод мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, мэдээллийг өгөх үүднээс энэхүү сургалтыг зохион байгуулж байгааг онцолсон юм.

Мөн сургалтад МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Баганат Өргөө ХХК-ийн зүгээс БНСУ-ын Hyundai engineering Plastics Co Ltd-тай хамтран Монгол Улсад галын системд ашиглах галд тэсвэртэй C-PVC хоолойг нутагшуулахаар зорин ажиллаж байгаа талаарх мэдээллийг хүргэлээ.

БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төсөл, түүнийг хамтран хэрэгжүүлэгч МБҮА ТББ-ын төслийн багаас барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах хүрээнд 2026.06.24-ны өдөр “Барилгын хог хаягдлын менежмент” сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгууллаа.

Сургалтыг ХААИС-ийн зөвлөх багш, доктор (Ph.D), профессор Л.Батмөнх “Барилгын хог хаягдал гэж юу вэ, хог хаягдлыг ангилан ялгах арга, тэмдэглэгээ”, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хими ногоон технологийн судалгаа, сургалт мэдээллийн мэргэжилтэн Н.Өнөр “Барилгын талбай дахь хог хаягдлын аюулгүй менежмент, дахин ашиглах, боловсруулах боломжууд” сэдвээр тус тус хийлээ.

МБҮА ТББ-иас зохион байгуулсан энэ удаагийн сургалтад идэвхтэй хамрагдсан Дулаалгын зөвлөхүүддээ KFI үнэлгээг өгч шилдгээр 5 зөвлөхөд цахилгаан дрилл гардуулж дараа дараагийн ажилд нь амжилт хүслээ.

ӨГЛӨӨНИЙ АЖИЛ ХЭРЭГЧ УУЛЗАЛТ

БАРИЛГЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХОМСДОЛ, ГАРЦ ШИЙДЭЛ СЭДЭВТ “ӨГЛӨӨНИЙ АЖИЛ ХЭРЭГЧ УУЛЗАЛТ” БОЛЛОО



МБҮА ТББ-иас сар бүр “Өглөөний ажилч хэрэгч” уулзалтыг зохион байгуулж байгаа бөгөөд 2026.05.27-ны өдөр БАРИЛГЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХОМСДОЛ, ГАРЦ ШИЙДЭЛ-ийн хүрээнд хөндөж зохион байгууллаа.

Тус арга хэмжээг нээж МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар Монгол Улсад үүсээд байгаа хөдөлмөрийн зах зээл, тэр дундаа барилгын салбарын ажиллах хүчний хомсдол зүй ёсны асуудал үүсгэж байгаа талаар оролцогчдод танилцуулаад Монголын барилгын салбарын ажиллах хүчний эрэлт хэрэгцээ, нөлөөлөх хүчин зүйлсийн судалгааг МБҮА ТББ-ын судалгааны ажилтан Б.Саранчимэг танилцууллаа.

Энэхүү судалгаагаар Монголын барилгын салбар дахь ажиллах хүчний эрэлтэд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг макро эдийн засаг, хүн ам зүй, институцийн тогтолцоо болон бодлогын хүрээний үүднээс нэгтгэн шинжилж, судалгааны үр дүнг гишүүддээ хүргэхийг зорьсон ба судалгаанд 2026 оны тавдугаар сарын байдлаарх албан ёсны статистик болон төрийн байгууллагуудын захиргааны мэдээлэл, олон улсын хөгжлийн банкны тайлангууд, эрдэм шинжилгээ болон бодлогын судалгаанууд, мөн зах зээлийн судалгааг эх сурвалж болгон ашигласан болно.

Мөн Техник технологийн Политехникийн Коллежийн захирал Ц.Баярмаа Ур чадвартай ажилтан бэлтгэх гарц, өнөөгийн байдал, Тогтвор суурьшилтай ажиллах ажилтан хэрэгтэй байна уу сэдвээр ЛБ Платинум Лайн ХХК-ийн Харилцагчийн менежер Б.Өлзийбат, Форум ланд ХХК-ийн захирал П.Оргил ХАЭБД ажил олгогч эздийн үүрэг оролцоо сэдвийн хүрээнд тус тус танилцуулга хийлээ.

Мөн ажил олгогчийн төлөөлөл МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Бармон ХХК-ийн захирал Ш.Үнэнбат ажил олгогчдод тулгамдаж байгаа асуудал болоод ажиллах хүчнээ хэрхэн тогтоож барьж байгаа туршлагаасаа хуваалцлаа.



БАРИЛГЫН НОРМ, НОРМАТИВЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТ

МБҮА ТББ нь энэ удаагийн “ӨГЛӨӨНИЙ АЖИЛ ХЭРЭГЧ УУЛЗАЛТ”-аа дэлхийн гоеполитекийн нөхцөл байдал нь Монгол Улсын эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа талаар Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөлийн Ажлын албаны дарга Б.Дөлгөөн болон Ажлын албаны Судалгаа, дотоод хяналтын менежер Б.Саранчимэг Шатахууны үнийн өсөлт барилгын өртөгт нөлөөлөх нь сэдвээр гишүүдэд мэдээлэл өгч ажиллалаа. Та бүхэндээ илтгэлийг тоймлон хүргэж байна.





ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН (REIT)-ГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫН ТАЛААР НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЛЭЭ

МБҮА ТББ-ын ээлжит “өглөөний уулзалт”-аар үл хөдлөх хөрөнгө оруулалтын сан (reit)-гийн хууль, эрх зүйн орчин болон олон улсын туршлагын талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүллээ.

Уулзалтад Санхүүгийн зохицуулах хороо-ны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн оролцож, REIT-ийн тогтолцоо дэлхий дахинд хэрхэн хөгжсөн, хөрөнгийн зах зээл болон үл хөдлөх хөрөнгийн салбарт ямар үүрэг гүйцэтгэдэг талаар танилцуулж, Монгол Улсад энэхүү эрх зүйн орчныг бүрдүүлэх



боломж, ач холбогдлын талаар мэдээлэл өглөө. Хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсад REIT-ийн зохицуулалт бий болсноор:

-Үл хөдлөх хөрөнгийн салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт татах,

-Барилгын компаниудын санхүүжилтийн шинэ эх үүсвэр бий болгох,

-Хөрөнгийн зах зээлийг гүнзгийрүүлэх,

-Property management болон түрээсийн зах зээлийг хөгжүүлэх,

-Иргэдэд үл хөдлөх хөрөнгийн зах зээлд шууд бус хэлбэрээр оролцох боломж бүрдүүлэх зэрэг олон эерэг үр нөлөө үүсэх талаар оролцогчид санал бодлоо солилцов.

Мөн REIT-ийн тогтолцоо нэвтрэхэд:засаглал,хөрөнгийн үнэлгээний ил тод байдал,хөрөнгө оруулагчийн эрх хамгаалалт, үл хөдлөх хөрөнгийн удирдлагын стандарт, зах зээлийн төвлөрлийн эрсдэл зэрэг асуудлыг анхаарах шаардлагатай талаар мэргэжлийн түвшинд хэлэлцлээ. Уулзалтад Санхүүгийн зохицуулах хороо-ны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Гүйцэтгэх захирал М.Энхбаатар, Сэлбэ 20 минутын хот корпорацийн захирил У.Баатар, БХТ ТӨҮГ-ын хэлтсийн дарга Д.Батням, Улаанбаатар Ассет Менежмент ҮЦК-ийн Гүйцэтгэх захирал Н.Монсор Таван богд холдингс ХХК-ийн Барилгын төсөл хариуцсан захирал Н.Агваангэлэг, А.Уянга болон салбарын компаниудын төлөөлөл оролцож, Монголын нөхцөлд REIT-ийн тогтолцоог хэрхэн

бодитой, тогтвортой хөгжүүлэх талаар өөрсдийн туршлага, байр сууриа хуваалцав. Үл хөдлөх хөрөнгө оруулалтын сангийн тогтолцоо нь анх 1960 онд United States-д үүсэж, өнөөдөр дэлхийн 40 гаруй улсад хэрэгжиж байгаа бөгөөд үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг институцийн түвшинд хөгжүүлэх чухал механизмын нэг болоод байна.

АРГА ХЭМЖЭЭ

“БАРИЛГЫН ТЕХНОЛОГИЙН ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ” ФОРУМ БОЛЛОО



Их Барилга 100 жилийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Монголын Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбоо-МАСС, Монголын Барилгын Зураг Төсөл Зохиогчдын Холбоо, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, ШУТИС-ийн Барилга Архитектурын Сургуультай хамтран “Барилгын Технологийн Өнөө ба Ирээдүй” форумыг 2026.05.26-ны өдөр зохион байгууллаа.
Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбоо ТББ-аас санаачлан зохион байгуулж буй энэхүү форум нь салбарын дараагийн шатны хөгжлийн талаар ярилцах маш чухал платформ бөгөөд Монголын барилгын салбарын өмнө зөвхөн барьсан барилгын тоогоор хэмжигддэг салбар хэвээр үлдэх үү, эсвэл инженерчлэл, технологи, бүтээмж дээр суурилсан өндөр бүтээмжтэй салбар болон хөгжих үү гэдэг сонголтын өмнө ирээд байгааг хамтаар хэлэлцлээ.
Уг арга хэмжээнд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан: ....Технологи нь зөвхөн ажлыг автоматжуулах хэрэгсэл биш, харин хүнээс хамааралтай процессоос системээс хамааралтай тогтолцоо руу шилжих боломжийг бий болгож байгаа том өөрчлөлт юм. Энэ өөрчлөлтийг хийхэд зөвхөн төр дангаараа хийхгүй. Зөвхөн хувийн хэвшил ч хийхгүй. Харин инженерүүд, мэргэжлийн холбоод, төр, хувийн хэвшил, их дээд сургуулиуд хамтдаа хийх шаардлагатай хэмээн онцоллоо.

УР ЧАДВАРТАЙ АЖИЛТНУУДЫГ БЭЛТГЭХЭД АЖ АХУЙН НЭГЖҮҮДТЭЙ ХАМТРАХААР БОЛЛОО




МБҮА ТББ нь үйл ажиллагаагаа сар бүр тодорхой уриа нэршилтэй болгон ажиллаж байгаа бөгөөд энэ 05-р сарыг Ажиллах хүчин тань бэлэн үү уриан доор төлөвлөгдсөн ажлуудаа хийж байна. Уг хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд Н.Учрал, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нар 2026.05.06-ны өдөр Монгол-Солонгосын Техникийн коллеж дээр зочилж ур чадвартай ажилтнуудыг бэлтгэхэд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн дэмжлэг туслалцаа их байгааг онцлон төр болоод хувийн хэвшлийн коллежуудыг томоохон аж ахуйн нэгжүүдэд дадлагажуулах, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор санамж бичигт гарын үсэг зурлаа.
МБҮА ТББ-ын Тэргүүн дэд Ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар тус арга хэмжээнд оролцож Монголын барилгын салбарын ажиллах хүчин болоод Монголын Барилгын Үндэсний Ассоциаци нь барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүний оролцоогүй, бүрэн цахимжуулсан талаар мэдээллийг хүргэлээ.




ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МАРКЕТИНГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

Барилгын салбарын 100 жилийн ой 2026 онд тохиож буйтай холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг сурталчлан, танилуулах, брендийг бий болгох зорилгоор салбарын онцлог, үнэ цэнийг агуулсан орчин үеийн дизайн бүхий Ассоциацийн Барилгын салбарын 100 жилийн ойд зориулсан ЛОГО-ны загвар дизайныг гарган, ашиглаж байна.
МБҮА ТББ-ын Ажлын албаны зүгээс 2026 онд тусгагдсан төлөвлөгөөт гишүүдэд болон олон нийтэд чиглэгдсэн ажлуудыг идэвхжүүлэх зорилгоор 42 төрлийн постер, 113 рийл, 427 мэдээ мэдээллийг бичиж нийтэлж байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан байна.










МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

WWW.MNCA.MN
2025 ОНД

МЭДЭЭ 427
РИЙЛ, ВИДЕО 113
ПОСТЕР 170
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 6



20K
ФБ ПЭЙЖ:
ДАГАГЧДЫН ТОО

8K
ФБ ПЭЙЖ:
ЛАЙК, ШЭЙРИЙН ТОО

156K
САЙТ:
ХАНДАЛТЫН ТОО

www.mnca.mn



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР



www.mnca.mn
976+7011-1515

ТҮНШЛЭГЧДИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ БОЛЖ ҮР ДҮНТЭЙ АЖИЛЛАСНЫГ ҮНЭЛЭВ



Монгол Улсад орчин цагийн барилгын салбарын 100 жилийн ой тун удахгүй болох гэж буйтай холбогдуулан барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж буй Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь Түншлэгч байгууллагын төлөөллүүд болох МБИХ ТББ, МБЗТЗХ ТББ, МБГБХ ТББ, ӨТМТҮХ ТББ, МБТХ ТББ, МБИГХ ТББ-ууд ээлжит хурлаа 2026.07.03-ны өдөр зохион байгууллаа.

Хурлаар:

2026 оны барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хэлтсийн эхний хагас жилийн үйл ажиллагаа болоод санхүүгийн тайлан, төлөвлөгөөний биелэлттэй танилцаж хангалттай гэж дүгнэлээ.

Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх танилцуулга хийж, санал авах

МБҮА ТББ НЬ БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ-ӨӨРЧЛӨЛТ-ШИНЭЧЛЭЛТ, ҮР ДҮНГИЙН ТАЛААР СҮХБААТАР, ӨМНӨГОВЬ, ДОРНОГОВЬ, ЗАВХАН АЙМГУУДАД АЖИЛЛАВ






Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жил, Сүхбаатар аймагт барилгын байгууллага үүсэж хөгжсөний 60 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан тус аймагт “Барилгын салбарын зөвлөгөөн 2026” арга хэмжээ 2026.05.09-ны өдөр боллоо.

Тус арга хэмжээнд Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам, БХТ ТӨҮГ, МБҮА ТББ, МБНХ болоод бусад төр болоод төрийн бус байгууллагынхан оролцлоо.

Уг арга хэмжээнд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар барилгын салбарт Фидик-ийг нутагшуулахад хэрхэн ажиллаж байгаа талаар болоод сургалтын талаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шинэ системийн бүтэц, зохицуулалт, хэрэгжилт-үр дүнгийн талаарх мэдээллийг салбарынханд хүргэлээ.

Мөн хагас жилийн хугацаанд Завхан, Дорноговь, Өмнөговь аймгуудад тус тус ажиллав.





БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2026 онд Зөвшөөрлийн цахим систем License.mn-ээр нийт **2161** хүсэлт хүлээн авч, **8206** инженер, техникийн ажилтны боловсролын мэдээлэл, давхцалыг шалгаж, **1905** аж ахуй нэгж байгууллагад Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгосон байна. Үүнд: Барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэх ажлын хүрээнд тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан **1569**, Зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан **290**, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх ажлын хүрээнд тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан **46** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан QR кодтой, цахим тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгож, суурь нөхцөл шаардлага хангаагүй **322** ААНБ-ын хүсэлт буцаагдсан байна.

Зөвшөөрлийн цахим систем license.mn-д хүсэлт ирүүлж, суурь нөхцөл, шаардлага хангаж баталгаажуулалт хийгдсэн ААНБ-уудын мэдээллийг 15 хоног тутам буюу сард 2 удаа ХБЗОСЯ-нд хүргүүлж, энэ оны тусгай зөвшөөрөл олголтыг нийт **11** удаагийн ХБЗОЯСайдын тушаалаар баталгаажуулан ажиллалаа.

Тусгай зөвшөөрөл олголтыг баталгаажуулсан ХБЗОСайдын тушаал гарсны дараа тухай бүр Барилгын салбарын нэгдсэн систем Mcis.gov.mn, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Opendata.gov.mn-д Барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл нь хүчинтэй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг тогтмол байршуулж байна. 2026 оны 5 сарын 26-ны өдрийн байдлаар Барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл нь хүчинтэй нийт **7949** аж ахуйн нэгж, байгууллага байна. Үүнд: Бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчинтэй **6423**, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл нь хүчинтэй **1292**, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчинтэй **234** аж ахуйн нэгж, байгууллага байна.

Барилгын тухай хуулийн 34.1.14 дэх заалт, Засгийн газрын 2014 оны “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 250 дугаар тогтоол, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын

Сайдын 2025 оны “Төрийн зарим чиг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай” 123 дугаар тушаалын дагуу “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан **7200** гаруй хувь хүн, хуулийн этгээдэд тухай бүр барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зөвөлгөө мэдээлэл өглөө.

Мөн Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Завхан аймгуудын барилгын салбарын аж ахуй нэгж байгууллагуудад барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл, зөвшөөрлийн цахим системийн шинэчлэлийн талаар сургалт, танилцуулга хийлээ.

Өмнө онуудад цаасан хэлбэрээр тусгай зөвшөөрөл олгогдсон, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь хүчинтэй нийт 6201 аж ахуйн нэгж, байгууллагын 6313 тусгай зөвшөөрлийн мэдээллийг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яаманд хүргүүлж, QR кодтой, цахим тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгож, цахим хэлбэрт шилжүүлэх ажил хийгдэж байна.


Тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусах дөхөж байгаа ААНБ-уудын жагсаалтыг 2 удаа гаргаж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд ил тод байршуулж, тусгай зөвшөөрлийн хугацаагаа сунгахыг сануулласа.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 09 дүгээр сарыг хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрөл авсан нийт 2641 ААНБ-н 11091 инженер техникийн ажилтны суурь нөхцөл, шаардлага хангаж байгаа эсэхийг үнэлэв. Үнэлгээгээр 1022 ААНБ шаардлага хангасан үзүүлэлттэй гарсан бол 1619 ААНБ шаардлага хангаагүй буюу зөрчилтэй байна.

Мөн БҮАТЗ-тэй холбоотой хууль бус үйл ажиллагааг багасгах зорилгоор тусгай зөвшөөрлийг олон удаа буюу 21 ААНБ дээр авсан 5 иргэнийг илрүүлэн уулзаж, салбарын яаманд мэдээлж, хуулийн байгууллагад шилжүүлээд байна.

Мөн барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хөнгөвчлөгдөж барилгын салбарт хүний оролцоогүй, ил тод, нээлттэй, түргэн шуурхай үйлчилгээтэй, аливаа дундын зуучлалгүй, салбарын инженер, техникийн ажилтнуудын статистик тоон үзүүлэлтийг нэгтгэсэн, ХҮНД СУРТАЛ, АВЛИГААС АНГИЖРУУЛСАН СИСТЕМ-ийг Монгол Улсад нэвтрүүлснээрээ онцлог, давуу талтай болсон ч тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хөнгөвчилснөөр инженерүүдийг олон компани зэрэг ашиглах, ИТА-г худалдан борлуулах буюу нэр ашиглах, тусгай зөвшөөрөлтэй компанийг худалдах, худалдан авах үүнийг дагасан хүний нөөцийн тогтворгүй байдал бий болж, чанаргүй барилга ихсэх хууль бус үйлдлүүд ихээр гарах болоод байгаа учир тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.







ДУЛААН ШИЙДЭЛ-2







“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛЛАА

Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан Шийдэл II" төслийн олон нийтэд чиглэсэн хаалтын арга хэмжээ 2026.04.17-нд амжилттай болж өндөрлөлөө. Уг арга хэмжээнд хүндэт зочноор Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц Бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайд Ина Марчюлёните болон Франц Улсаас Монгол Улсад суугаа Онц Бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайд Коринн Пэрера Да Силва тэргүүтэй төслийн санхүүжүүлэгчид, хамтран хэрэгжүүлэгчид, хамтран ажиллагч байгууллагууд болон үр шим хүртэгчид нийлсэн 70 гаруй хүн оролцов.

МБҮА ТББ нь нийгмийн хариуцлагын хүрээнд, тус төслийн хамтран хэрэгжүүлэгчээр 8 дахь жилдээ амжилттай ажиллаж байгаа бөгөөд амины орон сууцыг дулаалж, барилгын эрчим хүч, түлшний хэрэглээг багасгах замаар хүлэмжийн хийн ялгарал болон агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулах зорилготойгоор 2018-2022 онд 1-р үе шат, 2022-2026 онд 2-р үе шатаа амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Төслийн 2-р үе шатанд хамтран хэрэгжүүлэгчдийн нэгдсэн үр дүнгээр 200 гаруй барилгын салбарын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчийг чадавхжуулж, 4750 өрхийг дулаалан, 35000 тонноор хүлэмжийн хийн ялгарлыг бууруулаад байна.

Мөн иргэд, олон нийтэд зориулан “Амины орон сууцны дулаалгын шийдэл” багц гарын авлагыг **www.dulaalga.mn** веб сайтаас татан авч ашиглах боломжийг бүрдүүлэв.

Арга хэмжээний үеэр төслийн хамтран хэрэгжүүлэгч Монголын эмэгтэйчүүдийн сан нь төслийн хүрээнд өөрсдийн удирдан хэрэгжүүлж ирсэн “Хялбар шийдэл” аянд идэвх, санаачилгатай оролцож, агаарын бохирдлыг бууруулах үйлсэд бодит хувь нэмэр оруулсныг үнэлж, төслийн бусад хэрэгжүүлэгч байгууллагууддаа “Талархал” гардуулсныг гардан авлаа.



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn